

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-32
<hr/>	
1.Нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	5-9
2.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсох	9-23
3.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан	23-32

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны
4 дүгээр сарын 28-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Жангабыл, Д.Рэгдэл;
Тасалсан: С.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Б.Батцэцэг, Г.Нямсүрэн, С.Уянга нар байлцав.

Нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцав.

Уг асуудлыг 15 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Ц.Одхүү, мөн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, ахлах шинжээч И.Давааноров, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гэр бүл,

хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Янжмаа, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга П.Батбаатар, мөн газрын Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газрын дарга Н.Баярмаа, Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга У.Өнөрмаа, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн дарга Б.Ууганбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Б.Батцэцэг, Г.Нямсүрэн, С.Уянга, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш, ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга П.Батбаатар нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, П.Мөнхтулга, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга П.Батбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, ахлах референт Д.Бямбадулам, Ш.Цэцэг-Өлзий, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Янжмаа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун,

Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, мөн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Л.Төгсбаяр, Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Т.Түмэнжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Г.Эрдэнэбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Б.Батцэцэг, Г.Нямсүрэн, С.Уянга, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт Г.Нямдэлгэр, Т.Гоцбаяр нар байлцав.

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Янжмаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, О.Номинчимэг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлантай танилцав.

Уг асуудлыг 16 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 38 минут үргэлжилж, ирвэл зохих 21 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 81.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 15 минут.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Нийт 21 гишүүнээс одоогоор 12 гишүүн ирцэд орсон байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Даваасамбуугийн Ганбаа гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Сонгобайн Замира гишүүн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Халтмаагийн Баттулга гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, би Одсүрэнгийн Номинчимэг нар ирцэд орсон байна. Байнгын хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр манай Байнгын хороогоор 3 асуудал хэлэлцэх ёстой байгаа. Өмнөх 7 хоногт ирц хүрээгүйн улмаас хойшилсон асуудлууд байгаа учраас. Энэ 3 асуудлын эхнийх нь Нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг танилцуулна. Манай Золжаргал гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаад, бид энэ журамдаа d.petition буюу нийтийн өргөдлийн энэ журмыгаа сайжруулж, иргэддээ хүртээмжтэй болох асуудлыг хэлэлцэх ёстой байгаа.

Хэлэлцэх асуудлын 2 дугаарт иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх Засгийн газрын Хэрэг эрхлэх Газар /ЗГХЭГ/ болон Засгийн газар /ЗГ/-ын хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсоно. Та бүхэнд мэдээлэл очсон байх. Бид иргэдээс ирж байгаа өргөдөл гомдлын гүйцэтгэх засаглалтай холбоотой, хэрэгжүүлэх агентлагтай холбоотой асуудлуудыг тухайн яам, тамгын газар, агентлагуудад шилжүүлж, шийдвэрлэлтийн үүрэг даалгаврыг өгөөд хэрэгжилтийг нь хянадаг. Тэгэхээр энэ асуудлуудтай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт ямар шатад байна, яагаад зарим нь шийдвэрлэхгүй байна гэдэг энэ мэдээллийг сонсоно.

3 дугаарт, хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсоно. Энэ бүх Байнгын хороодоор өмнөх жил Улсын Их Хурал /УИХ/-аас гаргасан шийдвэрлэлтийн хэрэгжилтийг сонсож байгаа. Өргөдлийн байнгын хорооны хувьд 2025 оны 7 сард байгуулагдсан учраас бид байгуулагдсан хугацаанаас хойш ирсэн иргэдтэй холбоотой өргөдөл гомдлын

асуудал байгаа. Энэ тал дээр илүү ЗГ яаж ажилласан байна гэдэг энэ асуудлыг энэ удаагийн Байнгын хорооны чиг үүргийн хүрээнд сонсохоор ЗГХЭГ-аас мэдээлэл бэлдэж, мөн Улсын Их Хурлын Тамгын газраас энэ дээр хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан гаргаж, гишүүдэд тараасан байгаа. Ийм 3 асуудлаар бид өнөөдөр хэлэлцэхээр байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой Улсын Их Хурлын гишүүдээс саналтай гишүүн байна уу? Алга байна. Ингэхээр энэ дарааллынхаа дагуу хэлэлцэх асуудалдаа орьё.

Нэг.Нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэх асуудлын 1 дүгээрт Нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид, мэдээлэл мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье. Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч Жаргалсайханы Золжаргал таныг санал, дүгнэлтээ танилцуулахыг урьж байна.

Ж.Золжаргал: Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 30-ны 2 дугаар тогтоолоор Нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулах Ажлын хэсэг томилогдсон. Тэгээд 9 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 30 хүртэл чуулганы сүүлийн өдөр бид санал, дүгнэлтээ гаргасан. Ажлын хэсэг 3 удаа хуралдсан байна. Нэг удаа хэлэлцүүлэг хийсэн, Бодлого залуусын хяналт ТББ-тай хамтраад. Тэгээд Гэрэлт хөгжлийн тэмүүлэл, Эрдэнэтийн хотол олны хөгжлийн төв, Хил хязгааргүй алхам, Залуусын давлагаа, Гэрэлт цонх байшин, Нээлттэй нийгэм, Иргэн та хүч гэх мэт ийм төрийн бус байгууллагуудтай санал солилцсон, иргэд бас оролцсон. Малчдын дунд цахим нөгөө хүртээмж хэр байгаа талаар d.petition рүү ороход хэцүү байгаа талаар 200 орчим хүнд энэ Бодлого залуусын хяналт ТББ-аар дамжуулж, онлайн хэлэлцүүлэг хийсэн байгаа.

Ер нь гол үндсэн өөрчлөлтүүд иргэн өргөдөл цахимаар өргөдөл гаргадаг. Тэрний хугацаа тодорхой биш байна. Ямар хугацаанд хэлэлцээд, ямар үр дүн гаргасан нь байдаггүй. Заримыг нь авдаг, авдаггүй. Нөгөөх нь болохоор үйл явц нь ил тод биш байна гэдэг ийм 2 зүйл дээр маш их гомдол гаргадаг. Дээрээс нь нэмээд нөгөө хуулиар тогтоосон босго хэтэрхий өндөр байна, 33 мянга, 70 мянга, 100 мянга гэдэг өндөр байна, бага байвал яасан юм бэ? Хүнээс гадна хуулийн этгээд, байгууллага цахимаар өргөдөл гаргавал яах вэ, хүүхэд бас өргөдөл гаргамаар байна гэх мэтчилэн маш олон ийм сэдвүүдээр яриа болсон.

Гэхдээ босго оноо, байгууллага, хүүхэд гэдэг бол хуулийн өөрчлөлт. Бид одоо байгаа хуулийнхаа хүрээнд журмаа боловсруулаад хурдан ажиллуулахгүй бол нөгөө хариу үйлдэл report нь ил тод биш байна гэдэг утгаар зөвхөн журам дээрээ анхаарсан. Ингээд гол өөрчлөлтүүд нь өргөдөл хүлээж авлаа, 14 хоногийн дотор нийтэлнэ, шаардлага хангасан уу, хангаагүй юу гэж бий нөгөө Үндсэн хуулийн заалтууд, хүний эрхтэй холбоотой гэх мэтчилэн. Тэгэхдээ шаардлага хангасан ч нийтэлнэ, шаардлага хангаагүй ч нийтэлнэ. Шаардлага хангаагүй бол хангаагүй

гэдэг хуулийн үндэслэлтэй нь хамт нийтлэх. Долоо хоног тутамд Өргөдлийн байнгын хорооны ажлын алба ангилаад, шаардлага хангасан, хангаагүйгээр нь ангилаад тэгээд Байнгын хорооны даргад болон Тамгын газрын Тэргүүн дэд даргад танилцуулна. Ингээд явцыг нийтэллээ, тэгж хэлэлцлээ, ажлын хэсэг байгуулагдлаа гэдэг явцыг тухай бүр веб сайт дээр тавина.

Чуулганд буюу Байнгын хороонд эсвэл нэгдсэн хуралдаан дээр танилцуулах товыг урьдчилж өргөдөл гаргасан хүнд хүргээд, хэрвээ хүсвэл оролцох боломжоор хангана. Шийдвэр, гарсан шийдвэрийг байнга харуулах ийм тусгай цэс байгуулна. Тэгээд хүртээмжтэй байдал буюу харааны сонсголын бэрхшээлтэй, хэлний зарим энэ нээлттэй эх үүсвэрийг ашиглаж хэлний дүрэм шалгах, өөрөөр хэлбэл нэмэлт төсөв зардал болохгүй гэдэг утгаар нээлттэй дүрэм ашиглаж хэлний алдаа орчуулгын ийм программуудыг ашиглаж болохоор тусгаж өгсөн. Тэгээд мэдээж гар утас, компьютер, таблет гээд олон төрлийн хэрэгсэл дээр ашиглах боломжтой байна гэсэн ийм үндсэн өөрчлөлтүүдийг оруулсан байгаа.

Журмаа батлах болтол сүүлийн дүгнэлт дээр юу гэж гарсан бэ гэхээр Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 5, 22.5 дээр зааснаар хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын хороо нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам батлахгүй гэж заасан байгаа. Тэгэхдээ мөн хууль дээр Төрийн байгуулалтын байнгын хороо /ТББХ/ Гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дүрмийг ингээд батална гэж заасан байдаг. Тэгэхээр энэ нэмэлт, өөрчлөлтийг хийж байж журмаа батлах юм байна. Дээрээс нь нэгэнт Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хийж байгаа бол нөгөө босго оноо, байгууллага, хүүхэд гэх мэтчилэн гаргасан өргөдлүүдийг яах вэ гэдэг асуудлыг ярья гэж нэлээн олон хүмүүс санал гаргаж байсан.

Гэхдээ журмыг ямар ч байсан боловсруулаад, батлаад дууслаа гэж үзэж байгаа. Тэгээд аль болохоор хурдан ажилд оруулах нь хуульд их олон өөрчлөлт оруулснаас илүү чухал байх гэж үзэж байна. Журмын төслөө бүхлээр нь уншиж өгөх ёстой билүү, үгүй тийм ээ? Танилцууллаа баярлалаа.

О.Номинчимэг: Золжаргал гишүүнд баярлалаа. Энэ журмын төслийг та бүхэнд 4 сарын 7-ны өдөр тараасан байгаа. Цахимаар болон хайрцагар буюу цаасаар гишүүддээ бүгдэд нь тараасан байгаа. Энэ журам бидний манай Байнгын хороо байгуулагдаад өнгөрсөн намрын чуулганд хамгийн анхны байгуулсан ажлын хэсэг байгаа. Тэгээд тодорхой шалтгааны улмаас энийг бид хэлэлцэж амжихгүй явж байсан. Тэгээд гишүүддээ мэдээлэл хүргэхэд одоо яг Улсын Их Хурлын хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн ийм төсөл явж байгаа. Маргааш даргын дэргэдэх зөвлөл дээр хэлэлцээд, тэгээд нийт гишүүддээ танилцуулахаар Улсын Их Хурлын дарга өөрөө ажиллаж байгаа мэдээлэл та бүхэнд очсон байх.

Тэр хүрээнд ер нь Өргөдлийн байнгын хорооны чиг үүргийг илүү нарийвчлаад, тэгээд бидний байнгын хороо чинь ихэвчлэн энэ гүйцэтгэх засаглал байдаг юм уу, орон нутаг байдаг юм уу яг энэ гүйцэтгэл хэрэгжилт дээр асуудлууд гараад байна гэдгийг өнгөрсөн хугацаанд бид өргөдөл гомдол дээр нь тулгуурлаад авсан. Тэгэхээр Байнгын хорооны хувьд зөвхөн Өргөдлийн байнгын хороо ЗГ-т чиглэл өгдөг эрхтэй байхаар, ер нь шүдтэй болгоно гэсэн үг шүү дээ. Яг энэ асуудал дээр хууль яагаад хэрэгжихгүй байна, асуудлууд төрийн албан байгууллага, албан тушаалтнууд яагаад хууль зөрчөөд, хууль хэрэгжүүлэхгүй байна гэдэг дээр чиглэл

өгдөг ийм эрх авч байгаа. Мөн дээр нь энэ журмыг батлах эрхийг авах энэ хууль, эрх зүйн орчныг нь тэр хуульд хийж өгч байгаа.

Та бүхэнд 2 долоо хоног тутамдаа Өргөдлийн байнгын хороон дээр ирж байгаа өргөдөл, гомдлын мэдээлэл, төрөл, ангилал, мөн d.petition буюу нийтийн өргөдлийн систем дээр ямар өргөдлүүд ирж байгаа гэдэг энэ мэдээллийг өгч байгаа. Тэгээд энэнийхээ дагуу бид Байнгын хороон дээрээ юуг авч хэлэлцэж, ямар шийдлүүдийг гаргах вэ гэдгийг хэлэлцэхэд энэ журмыг бид сайжруулах шаардлагатай байгаа юм. Золжаргал гишүүний хийсэн ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан d.petition-ний журам дээр асуулт асуух гишүүд байна уу? Гишүүд нэрсээ өгөөрэй. Асуулт асуух гишүүд маань байхгүй байх шиг байна. Тэгвэл би гишүүнийхээ хувьд нэг асуулт асууя гэж бодож байна.

Тэгээд d.petition дээр яг бодит байдал ингэдэг юм байна лээ л дээ бид яг ажлын албан дээрээ аваад харахаар өргөдөл гаргагч d.petition дээр нэг өргөдөл d.petition нээлгэчихдэг, 2 долоо хоног ерөөсөө ингээд яаж байгаа нь мэдэгдэхгүй алга болчихдог. Тэгээд тэр нь яах вэ нөгөө дотооддоо бид Өргөдлийн байнгын хороо, дээр нь Тамгын газар дээр яг энэ өргөдлийг нийтлэхгүй юү, нийтлэхгүй юү, нийтлэх үү гэдэг энэ шүүлтүүрийн процесс явдаг. Тэр нь 1 дүгээрт удаан байгаад байдаг. Тэгээд нөгөө санал гаргасан хүмүүс маань бидний өргөдөл яачхав гээд. Тоо баримт харвал нийтдээ гаргаж байсан иргэдийн өргөдлөөс дөнгөж 20, 30 хувь нь л нийтлэгдэж байгаа ийм тоо байна лээ. Жишээ нь өнгөрсөн долоо хоногт 2 долоо хоногийн хугацаагаар авч үзвэл нийт 21 яах вэ ирүүлсэн өргөдөл байгаа юм, тэгээд надад ирж ингээд танилцуулахдаа ихэнхийг нь нийтлэхгүй, нийтлэхгүй. Ямар асуудлаар, яагаад нийтлэхгүй гэж байгаа юм бэ гэхээр өмнө нь төстэй асуудал гарчихсан, эсвэл төстэй асуудал явж байгаа гэдэг байдлаар ингээд тийм жоохон субъектив байдлаар тэр болгоныг ингээд хасчихдаг асуудал байна Тамгын газар дээр. Үгүй ээ, тэгээд та нар нэгэнт яваад дуусчихсан юмыг дахиад энэ хүмүүс өргөдөл гаргаж байна шүү дээ. Яагаад энийг нь нийтлэхгүй байгаа юм бэ?

2 дугаарт тэр юу гэдэг юм НӨАТ-ын босгыг нэг нь 400 сая болгоё гээд, нэг нь 2,5 тэрбум болгоё гээд өргөдөл гарчихсан байхад төстэй асуудал юм чинь гээд нэгийг нь нийтлэхгүй байгаа байхгүй юу. Энэ чинь шалгуур нь шал өөр шүү дээ 400 сая, 2,5 тэрбум гэдэг энэ асуудал өөр шүү дээ гээд. Яагаад энийг ингээд субъектив байдлаар энэ дээр нь хасаад байна гэдэг асуудал байгаа юм. Тэгээд энэ бүгдийг нь засаад ингээд яахаар 21 өргөдлөөс 13 нь яах вэ нийтлэгдэж байгаа юм л даа. Тэгээд эргээд тэр 8 хүнд нь өргөдөл яагаад нийтлэгдээгүй вэ гэдгийг бид аль түвшиндээ яаж мэдээлж байна гэдэг энэ систем 1 дүгээрт байхгүй.

2 дугаарт нийтлэхгүй байх энэ шийдвэр миний харж байгаагаар Тамгын газар дээр субъектив байдлаар шийдэгдээд байгаа юм. Тэгэхээр Золжаргал гишүүний яг энэ ажлын хэсэг дээр гол нь энэ чинь иргэд нөгөө оролцоотой байх, миний өгсөн өргөдөл яаж байна гэдэг мэдээллийг иргэддээ нээлттэй өгч байх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ дээр энэ байршуулах юм уу, байршуулахгүй юу гэдэг мэдээллийг хэн гаргаж, ямар хугацаанд тэрийг шийдэх гээд байна, тэрийгээ яаж иргэдэд дахиад мэдээлэх вэ гэдэг дээр журмын төсөлд яаж тусгасан байгаа вэ гэдгийг та хэлээч? Яагаад гэвэл үүнтэй холбоотойгоор иргэдээс их гомдол ирж байгаа юм. Миний эхлүүлсэн Туулын голтой холбоотой 10-аад жишээ нь Туулын хурдны замтай холбоотой өргөдөл d.petition дээр орж ирээд, тэндээс хоёрхон нь нийтлэгдэж байгаа. Яагаад гэвэл зарим нь адилхан агуулгатай байна гээд. Тэгээд бид энэ адилхан агуулгатай юмнуудтайгаа адилхан гээд иргэн А-ийн хамгийн эхэнд өгсөн

гэдэг өргөдлийг нь нийтлээд, иргэн Б-ийн нэг хоногийн дараа нээсэн өргөдлийг нь нийтлэхгүй байх юм уу, адилхан бүгдийг нь нийтлээд явах юм уу? Яагаад нийтлэхгүй байгаа юм бэ гээд би Тамгын газраас асуухаар адилхан агуулгатай юмыг чинь 2 юм нээчихээр сарничихна гээд байгаа байхгүй юу. Тэгээд тэр сарних, сарнихгүйг бид энд Тамгын газар шийдэх ёстой юм уу, эсвэл иргэд өөрсдөө тэр санаачилга гаргаж байхад бүгдийг нь адилхан нийтлээд, энэ дээрээ хэн нь өөрсдөө яаж саналаа өгөх вэ гэдгээ шийдээд явах ёстой юм уу? Энэ дээр таны журам дээр шийдэл байгаа болов уу гэдэг дээр асуулт хариулт авъя.

Ж.Золжаргал: Журмын төслийн 3.5-д Өргөдлийн байнгын хорооны ажлын алба гаргасан өргөдлийг шаардлага хангасан эсэхээр нь ангилаад, тэгээд Өргөдлийн байнгын хорооны дарга, Тамгын газрын Тэргүүн дэд дарга нарт долоо хоног тутамд танилцуулна. Өөрөөр хэлбэл ямар өргөдлүүд ирсэн, энэ нь шаардлага хангаж байна, хангахгүй байна гэдгийг 7 хоног болгон байнгын процессоор танилцуулна. Тэгээд өргөдөл гаргасан өдрөөс хойш 14 хоногийн дотор веб сайт дээр нийтэлнэ, шаардлага хангасныг нийтэлнэ, шаардлага хангаагүйг нийтэлнэ буюу бүгдийг нийтэлнэ гэсэн үг.

Тэгээд 3.9 дээр болохоор нэг болон олон иргэний санаачилсан өргөдөл давхардсан агуулгатай байх тохиолдолд өргөдөл гаргагч иргэн тус бүр мэдээлж, зөвшилцөн өргөдлийг нэгтгэн цахим системд нийтэлж болно гэсэн заалт нэмж оруулсан. Өөрөөр хэлбэл хэрвээ давхардсан ижил утгатай байвал ажлын албанаас өргөдөл гаргагч руу холбогдоод, зөвшилцөөд болж байна гэвэл нэгтгэж гаргана. Хэрвээ ингэж асууж зөвлөөгүй бол журмынхаа дагуу бүгд нийтлэгдэнэ гэсэн үг.

3.3 дээр өргөдөл авснаас хойш 14 хоногийн дотор шаардлага хангаж байгаа талаар үндэслэлийн хамт өргөдөл гаргагчдад мэдэгдэж, тэмдэглэл хөтөлж, цахим системд нийтэлнэ гэж байгаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Ер нь шаардлага хангасан, хангаагүй аль алийг нь нийтлээд, иргэдээс ийм өргөдөл гарсан байна, энэ шаардлага хангаагүй учраас санал авахгүй, энэ нь бол хуулийн дагуу шаардлага хангасан учраас санал авна гэдгээр нь ялгаж бүгдийг нь нийтэлдэг болъё гэсэн ийм шийдэл журамд орж ирж байгаа юм байна. Хэрвээ нэгтгэх бол өргөдөл гаргагчтай нь хоёулантай нь холбогдож, нэгтгэх эсэх дээр нь саналыг нь авах нь байна. Тэгээд нэг нь нэгтгээ гээд, нэг нь нэгтгэхгүй гэвэл нэгтгэхгүйгээр нь л байна гэж ойлгож болох уу? Санал нэгдэхгүй байвал? Тэгэх нь байна. Тэгэхээр энийг иргэддээ зөв ойлгуулж таниулах ажлыг бид хийх ёстой байх гэж бодож байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу d.petition журам дээр иргэддээ илүү ээлтэй, нээлттэй болох асуудал дээр? Алга байна. Нийтийн өргөдөл хүлээн авах, нийлэх, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцүүлж дууслаа. Гишүүд маань энэ журмын төсөл бүгдэд нь очсон байгаа учраас санал байвал ажлын албанд ирүүлээд, бид дараагийн шатад энэ журмаа баталж, дагаж мөрдөх хэм хэмжээ болгоно гэдэг дээр анхаараад саналаа өгөөрэй гэдгийг хэлмээр байна. Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудлын 2. Золжаргал гишүүн ажлын хэсгийн ахлагч.

Ж.Золжаргал: Нийтийн цахим өргөдлийн журмын төсөл дээр хамтарч ажилласан Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал, Замира, Мөнхбаясгалан, Мөнхтулга, Сарнай, Эрдэнэбат нарт баярлалаа.

О.Номинчимэг: Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

Хоёр.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсох

Дараагийн асуудалдаа орёе. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар ЗГХЭГ болон ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг хэлэлцэнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Энэ асуудалтай холбоотойгоор Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга Баттөмөрийн Энхбаяр сайд оролцож байна, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батбаатар оролцож байна, Хууль зүй, дотоод хэргийн яам /ХЗДХЯ/-ны /Төрийн нарийн бичгийн дарга/ ТНБД Мягмар ирсэн байна, Эрүүл мэндийн яам /ЭМЯ/-ны ТНБД Эрдэнэбаяр ирсэн байна, ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /ХШҮДАГ/-ын дарга Бат-Эрдэнэ ирсэн байна, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын Архив, нууц албан хэрэг хөтлөлтийн хэлтсийн дарга Болор-Эрдэнэ ирсэн байна, ЗГХЭГ-ын ХШҮДАГ-ын ахлах шинжээч Давааноров ирсэн байна, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Баярмаа ирсэн байна, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого, төлөвлөлтийн газрын Бодлогын судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн ажилтан Өнөрмаа ирсэн байна, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /НЗДТГ/-ын Төрийн захиргааны удирдлагын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн дарга Ууганбат ирсэн байна.

Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Баттөмөрийн Энхбаяр таныг иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг танилцуулахыг урьж байна.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын дарга, гишүүд болон Байнгын хороодоос ЗГХЭГ, яам, агентлаг, НЗДТГ-т шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс 2026 оны 3 сарын 31-ний өдрийн байдлаар нэгтгэн 284 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцыг та бүхэнд хавсралтаар танилцуулж байна. Шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн өргөдөл, гомдолд дараах асуудлууд хандалт өндөртэй байна.

Гадаад оронд эмчлүүлэх өндөр өртөгтэй эмчилгээний зардал санхүүгийн дэмжлэг хүссэн, эмч, эмнэлгийн ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг нэмэх, ажиллах нөхцөлийг сайжруулах, Эрүүл мэндийн даатгал /ЭМД/-ын хөнгөлөлт, орон нутгийн эмнэлэгт шаардлагатай тоног, төхөөрөмж тусламж, үйлчилгээний автомашины хангалт, хүнд өвчтэй удаан хугацаанд эмчилгээнд байдаг иргэдийн эмийн хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг асуудлаар гаргасан иргэдийн хандалт 19,4 хувь, Боловсролын зээлийн санд хамрагдах, гадаад улсын их, дээд сургуульд суралцахад

санхүүгийн дэмжлэг хүссэн, аймаг, орон нутаг дахь сургуулийн барилгын хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэх санал хүсэлт 17,3 хувь, тэтгэвэр тогтоолгох, нэмэгдүүлэх, өвлүүлэх, цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмж, халамж, үйлчилгээнд хамрагдах, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгох, ахмадын орон сууцын хөтөлбөрт хамрагдах зэрэг нийгмийн хамгаалал, хөдөлмөр, халамж, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал 7,4 хувь, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, өргөн баригдсан хууль тогтоомжийн төслийг батлуулах, гэмт хэрэг, зөрчлийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлүүлэх, шашны байгууллагын хууль бус үйл ажиллагаанд хяналт тавих, эрүү, иргэний хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтэд хамрагдах асуудлаар 4,6 хувийг тус тус эзэлж байгаа нь хамгийн өндөр хандалттай байна.

Мөн барилга, орон сууцын чанар, барилгын явц удаашралтай байгаа тухай болон барилга ашиглалтад оруулахад үүсэж буй хүндрэл бэрхшээл, орон сууцтай болоход санхүүгийн дэмжлэг хүссэн, түрээсийн орон сууцад хамрагдах газрын харилцаатай холбоотой асуудлууд ч тодорхой хувийг эзэлж байна. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн зарим өргөдөл гомдол нь хууль тогтоомжийн хүрээнд шууд шийдвэрлэх боломжгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Үүнд, иргэн хуулийн этгээдээс гаргасан өргөдөл гомдолд орон сууцын урьдчилгаа төлбөр, гадаад улсад эмчлүүлэх эмчилгээний зардал, зээл авах, зээл төлөхөд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагын шийдвэртэй холбоотой асуудлаар гомдол гаргаж, шийдвэрийг хянуулах, цуцлуулах хүсэлт, хуулийн этгээдээс гаргасан зарим хүсэлтэд өөрсдийн боловсруулсан өндөр өртөгтэй төсөл, хөтөлбөрт санхүүгийн дэмжлэг хүссэн, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын ивээл дор олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, хурал зөвлөгөөн зохион байгуулах, уг арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг хүссэн хүсэлтүүд байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц өндөр хувийн үзүүлэлттэй байгаа боловч нэг асуудлаар зэрэг олон байгууллага, албан тушаалтанд хандах, шийдвэрлэх боломжгүй асуудлаар дахин, дахин хандаж байгаа өргөдөл гомдлын тоо нэмэгдэж, уг асуудлыг эрхлэх асуудлын хүрээний дагуу холбогдох байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн тоон мэдээнд орж байгаагаас шийдвэрлэлтийн хувь өндөр гарч байна. Дээрх асуудлыг цэгцлэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд чанарын ахиц гаргах, төрийн албан хаагчийн хариуцлагыг сайжруулахад анхаарч, олон эх үүсвэрээс ирж байгаа өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн байдлаар хянаж, давхардал, тоон дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тодруулах, хариу арга хэмжээ авах, иргэн, хуулийн этгээд өөрийн гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн явц байдлыг хянах боломжийг бүрдүүлэх асуудлыг ЗГ-ын хуралдаанд танилцуулж, 2024 оны 13, 33, 2025 оны 15, 16 дугаар хуралдааны тэмдэглэл өгсөн үүргийн дагуу ЗГХЭГ, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газар, ИМонгол академи хамтран өргөдөл, гомдлын нэгдсэн цахим систем хөгжүүлж, 2025 оны 11 дүгээр сараас яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ, түүний харьяа байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн дотоод удирдлагын системийг нэгтгэн, нэгдсэн сангийн холболт хийгдэж, ашиглалтыг жигдрүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын дарга, УИХ, ЗГ-ын зарим гишүүд 2026 оны 1, 2 дугаар сард Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт ажилласан дүн, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийн талаар ЗГ-ын 2026 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 6 асуудлыг хэрэгжүүлэхээр, ЗГ-ын хуралдааны 2026 оны 4 дүгээр тэмдэглэлээр Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймагт ажилласан дүн, иргэдээс гаргасан санал, хүсэлтийн талаар ЗГ-ын 2026 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 20 асуудлыг хэрэгжүүлэхээр, ЗГ-ын хуралдааны 2026 оны 5 дугаар тэмдэглэлээр Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл аймагт ажилласан дүн, иргэдээс гаргасан санал хүсэлтийн талаар ЗГ-ын 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 18 асуудлыг хэрэгжүүлэхээр, ЗГ-ын хуралдааны 2026 оны 9 дүгээр тэмдэглэлээр тус тус ЗГ-ын гишүүд, зарим агентлагийн дарга, аймгийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Уг томилолтын үед иргэд, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг нэгтгэж, Улсын Их Хурлын Тамгын газраас 5 удаа албан бичгээр ирүүлснийг холбогдох агентлаг, яам, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт албан бичгээр уламжлан, хэрэгжилт, үр дүнд хяналт тавин ажиллаж байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Энхбаяр сайдад баярлалаа, танилцуулга хийлээ. Энийг үргэлжлүүлээд ЗГ-ын Хяналт хэрэгжилт газрын дарга Батбаатар мөн яг энэ бидний шилжүүлсэн өргөдөл, гомдол хэрэгжилт хэр байгаа талаар мэдээлэл танилцуулна. Батбаатар дарга 3 номерын микрофоныг нээгээд танилцуулга хийхийг урьж байна.

П.Батбаатар: ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батбаатар. Өргөдлийн байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хяналт хэрэгжүүлэх газар дээр өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлын гишүүд, Үндсэн хуулийн цэц /ҮХЦ/-ээс нийт 8 өргөдөл, гомдол, санал ирүүлсэн байгаа. Энэ нь бол биелэлтийн талаар 2 санал, 2 хүсэлт, иргэний өргөдлийг уламжилсан 1, мэдээлэл ирүүлэх тухай 2, санал хүргүүлэх тухай 2, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1, хяналт шалгалт хийх тухай холбоотой 1 гэсэн ийм өргөдөл, гомдлыг ирүүлсэн. Энэ өргөдөл, гомдлуудыг бол ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газраас дундаж 17 хоногийн хугацаанд дунджаар ингэж шийдвэрлэсэн байгаа.

Мөн 2025 оны улсын хэмжээний өргөдөл, гомдлын тайланг та бүхэнд товчхон танилцуулъя. Үндсэндээ өнгөрсөн хугацаанд 16 яам, 31 агентлаг, нутгийн захиргааны байгууллага буюу аймаг, нийслэл ЗДТГ-ын 22 байгууллага, ингээд нийт 38 байгууллага дээр 2025 оны жилийн эцсийн байдлаарх өргөдөл, гомдол ирүүлсэн талаарх мэдээллийг товч хүргэе. Нийт 341506 өргөдөл ингээд ирсэн. Энэ өргөдлийн хугацаандаа ирүүлсэн байдлаар бол 28 байгууллага 73,6 хувьтай, хугацаа хоцорсон 10 байгууллага, удирдлага болон зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн холбогдох журам, дүрмийн дагуу хэлэлцүүлсэн 22 байгууллага, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн 31 байгууллага мэдээллээ хугацаанд нь ирүүлсэн байна.

Үүнийг дотор нь ангилж авч үзвэл 178 мянга орчим өргөдөл дотроо хүсэлтийн шинж чанартай, 97 мянган өргөдөл бол гомдлын шинж чанартай, ингээд 30 мянган санал, 34 мянга нь мэдэгдэл талархлын шинж чанартай ийм өргөдөл, гомдол, хүсэлтүүд ирсэн байгаа. 341 мянган өргөдлөөс 321186-г нь бол шийдвэрлээд 94,1 хувиар өргөдөл, гомдол бол шийдвэрлэлтийн өндөр хувьтай байгаа. өрийн захиргааны төв байгууллагад бол эндээс 164 мянга орчим буюу 48,19 хувийн

өргөдөл бол ирдэг. Нутгийн захиргааны байгууллага 176951 буюу 51,81 хувийн өргөдөл бол ингэж ирсэн байдаг.

Энийг ямар сувгаар ирж байгааг нь ангилаад үзвэл биеэр 160 мянга орчим иргэн өргөдөл, гомдлыг ирүүлсэн байна, утсаар 26 мянга орчим, цахимаар 54 мянга, 11 11 төвөөр 66 мянга орчим, 65 мянга гаруй, албан бичгээр ингээд 36 мянга орчим өргөдөл, гомдол ирүүлсэн байдаг. Үүнийг шийдвэрлэлтийн талаар түрүүнд товчхон дурдсан. Яамнуудын шийдвэрлэлтийн байдлыг товчхон харуулж байна. Өргөдөл гомдлыг бол нутгийн захиргааны байгууллагаар ялгаж үзвэл газартай холбоотой маргаан 33 орчим хувь, орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн байгууламж, дэд бүтэцтэй холбоотой өргөдөл гомдол 20 хувь, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 10 хувь, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаатай нь 10 хувь, гудамж талбай, тохижилтын үйлчилгээтэй холбоотой 8 орчим хувь, авто замтай холбоотой 8 хувь, барилга байгууламжтай холбоотой 7 хувь, боловсролын салбартай холбоотой 7 хувь, байгаль орчны үйл ажиллагаатай холбоотой 5,88 хувь, хууль, шүүх, цагдаатай 5,59 хувь гэсэн ийм гомдлууд бол орон нутгийн буюу нутгийн захиргааны байгууллагад ирсэн байдаг.

Төрийн захиргааны байгууллагын ирсэн өргөдлийг бол эзлэх хувиар нь авч үзвэл НӨАТ болон И баримттай холбоотой өргөдөл, гомдол 30 орчим, төрийн цахим үйлчилгээтэй холбоотой 18 орчим, нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой 14 орчим, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 7 орчим, хууль сахиулах байгууллагатай холбоотой 6 орчим, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 5,4 хувьтай, тээврийн салбар үйл ажиллагаатай 5,35 хувьтай, төрийн албан хаагчийн гомдолтой холбоотой 4,71 хувь, эрүүл мэндийн салбартай холбоотой 3,47, боловсролын үйл ажиллагаатай холбоотой 2,29 гэсэн ийм өргөдөл, гомдлуудыг хувьчилж үзвэл тоон задаргаатайгаа ирсэн байна.

Өнгөрсөн жилийн хугацаанд бол харьцуулж үзэхэд өнгөрсөн жил 446 мянга орчим өргөдөл, гомдол ирсэн. Энэ жил бол 340 орчим мянгаар буюу өргөдөл, гомдлууд 104 мянга орчмоор ингэж буусан байгаа. Үүний шалтгаан бол 1 дүгээрт, төрийн байгууллагын албан хаагчаас тухайн байгууллага доторх өргөдөл, гомдол болон төрийн үйлчилгээг иргэн хүсэлтээр авах хүсэлтүүд нь энд орсон учраас 100 орчим мянгаар буурсан ийм үзүүлэлттэй харагдаж байгаа.

Иргэдийн сэтгэл ханамжийг тодорхой хэмжээнд судалгааг 2 яам, 1 агентлаг, 2 аймагт тулгуурлан ирсэн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар, яаманд 309 иргэн, агентлагаас 34, аймгаас 360 ингээд нийт 703 иргэнээс сэтгэл ханамжийн судалгааг ингэж авч үзсэн байгаа. Үүн дээр бол эргэн мэдээлсэн асуудал Эрчим хүчний яам /ЭХЯ/ дээр 80 орчим, Боловсролын яаман дээр 47, Мал эмнэлгийн газарт 59 хувиар иргэдэд өргөдөл, гомдлын хариуг эргэн мэдээлсэн. Аймгуудаас түүврийн аргаар хийсэн Дорнод аймаг, Төв аймаг бол иргэдэд эргээд өргөдөл гомдлынх нь талаар мэдээллийг Дорнод аймаг 48, Төв аймаг бол 67 хувиар ингэж өргөдөл, гомдлынхоо эргэн мэдээлсэн ийм үзүүлэлтүүд болбол байна.

Монгол Улсын ЗГ-аас dashboard.gov.mn цахим системийг ашиглалтад ороод явж байгаа. Энэ систем дээр өнөөдрийн байдлаар дотоод удирдлагын буюу ERP системийг нийт 17 хувийн хэвшлийн байгууллага нийлүүлдгээс өнөөдрийн байдлаар 3 байгууллага энд өргөдөл, гомдлоо мэдээллийн нэгдсэн санд шууд нэгтгэсэн байгаа. Энэний дүнд тодорхой өргөдлийг цахимаар шийдвэрлэх, байгууллага хоорондын энэ цахимаар ирж байгаа ERP өргөдөл, гомдлыг нэгдсэн

нэг системээс бүрэн хянах боломжтой болсон байгаа. Ингээд dashboard.gov.mn цахим системийг төрийн 125 орчим мянган албан хаагчид эрхийг нь нээгээд өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар мэдээллийг авах ийм бүрэн боломжтой байгаа. Одоогийн байдлаар систем 2025 оны 11 дүгээр сард нэвтэрснээс хойш цахим системээр системээр 47204 иргэн гомдлоо, өргөдөл, гомдлоо ирүүлсэн ийм тоо байна. Товчхон танилцуулж дууслаа. Баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Өнөөдөр ЗГХЭГ-ын дарга, Монгол Улсын сайд Батмөрийн Энхбаяр болон ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батбаатар нарын хийсэн танилцуулга мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Мөнхтулга гишүүнээр, 2 гишүүнээр тасаллаа. Ганмаа гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Сайн байцаана уу? Хэдэн асуулт тодруулъя. Эрүүл мэндээс, ЭМЯ-наас. Мэдээж нөгөө Төрийн нарийн томилогдоод удаагүй байгаа, тэгэхдээ бараг санал солилцох байдлаар асуулт асууж тодруулж байгаа. Ер нь төлөвлөгөө дараа дараагийн ажил нь юу вэ гэдэг талаас нь илүү ярьж байгаа гэж ойлгоорой. Харахад зүгээр ингэж байна л даа ЭМЯ-нд ирж байгаа иргэдийн гомдол нь 55 өргөдөл байгаагаас асуудлыг шийдчихсэн гэдэг нь 54, ингэхээрээ зэрэг 98,1 хувьтай хамгийн өндөр үзүүлэлттэй хүлээгдэж байгаа 1, тэр нь хууль тогтоомжийн хүрээнд шийдэх боломжгүй гэсэн байдлаар хүлээгдэж байгаа юм байна гэж ойлголоо. Хамгийн өндөр гэж байгаа боловч энэ шийдвэрлэгдсэн асуудлууд нь яаж шийдвэрлэгдэж байна гэхээр ихэвчлэн төсөлд юм уу, гадаадын зээлд хамруулъя ч гэдэг юм уу нэг тиймэрхүү байдлаар болохоос биш, яг углуураар нь асуудлаа шийдээд дахиж үүсэх нөхцөл байдлыг багасгах талаар гэхээсээ илүүтэйгээр нэг тийм шинж тэмдгийн байдалтай хандсан юм шиг харагдаад байгаа юм.

Тэгээд гол ирж байгаа асуудлуудыг нь багцлаад харахаар хэд хэдэн юмнууд байна л даа яг давтагдаж байгаа. 1 дүгээрт, эмч, эмнэлгийн ажилчдын албан хаагчдын цалин хөлсийг нэмэх, нөхцөлийг сайжруулах, ЭМД-ын сангийн тогтолцоо, зарцуулалтыг ил тод болгох, орон нутгийн эмнэлэг, тоног төхөөрөмж, автомашин, ялангуяа нөгөө юу гэдэг билээ хөдөө орон нутагт явах тийм автомашинаар хангах, хүнд өвчтэй, удаан хугацаанд эмчилгээнд байдаг иргэдийн эмийн хөнгөлөлт, чөлөөлөлт гэсэн ийм асуудлууд байгаад байгаа юм. Тэгэхлээр энэ дээр би нэг багцлаад асуувал цалингийн асуудал дээр мэдээж яг нөгөө намрын чуулганаар энэ Өргөдлийн байнгын хороотой ярьж байсан асуудал. Тэгээд төсөв дээр оруулж ирээд ерөнхийдөө сая томилогдсон Засаг, Ерөнхий сайд, шинэ сайд ч гэсэн ер нь цалингийн асуудлуудаа шийдэгдэхээр ярилцаад байгаад баяртай байгаа. Тэгэхлээр энэ дээр асуух асуултаа түр азная цаг бага байгаа учраас.

Хэд хэдэн асуудал байгаа нь жишээлбэл тэр өндөр өртөгтэй машин, тоног, төхөөрөмж гэдэг дээр өнгөрсөн ЗГ-аас би авсан тоног, төхөөрөмжүүдийг бүсийн, улсын хэмжээнд авах гээд одоо хүртэл тэр тоног, төхөөрөмжийн жагсаалтуудыг гаргаж надад өгөхгүй байна. Би бүүр template үүсгээд хэдээс хэдэн төгрөгийн үнэтэй ямар, ямар тоног, төхөөрөмж аль гэдгээс асуусан. Яагаад асуугаад байгаа вэ гэхээр чинь зэрэг нөгөө хөдөө орон нутгуудыг ингээд харахаар зэрэг яг ямар эрэмбээр, ямар технологийн үнэлгээ жишээлбэл хийдэг үү, үгүй юу тоног, төхөөрөмж авахдаа, ямар газарт нь машин аваад, ямарт нь авахгүй байна, бодит хэрэгцээндээ суурилж чадаж байна уу, үгүй юу энэнийхээ эрэмбээ яаж тогтоож байгаа юм, аль, аль аймгуудад нь, аль, аль аймгууддаа авахгүй байна энэ нь ил тод байж чадаж байна уу, үгүй юу. Зөвхөн хувь хүний юм уу, тийм subjective юмнаас болж байна уу, үгүй

юү гэдэг эдгээр асуулт байна. Ингээд бодитой яаж дүгнэж, яаж эрэмбэлж яаж, тоног, төхөөрөмж, машиныхаа асуудлаа шийддэг вэ гээд ганцхан асуулт дээр цаг дуусчихлаа.

О.Номинчимэг: 6 номер нэрээ хэлээд асуултад хариулья.

Н.Эрдэнэбаяр: ЭМЯ-ны ТНБД Эрдэнэбаяр. Ганмаа гишүүний асуултад хариулья. Саяын дурдагдсан 55 өргөдөл үндсэндээ Их Хурлын дарга болон гишүүдээс ирсэн өргөдлүүдийг зөвхөн илэрхийлсэн тоо байж байгаа. Ер нь энэ дээр бид тодорхой хариултуудыг би судалж үзсэн байж байгаа. Энэ өгсөн хариултуудыг судалж үзэхэд яг таны хэлээд байгаатай санал нэг байна. Зарим нэг зүйл дээр илүү ийм процессын шинж чанартай ийм тайлбарууд ороод ирсэн байж байгаа. Ер нь цаашдаа бид дотоод ЭМЯ-н дээрээ ярилцаж байгаа нэг гол зүйл энэ төрийн байгууллагууд болон Их Хурлын гишүүдээс ирж байгаа саналууд, дээрээс нь иргэдээс ирж байгаа саналуудыг ер нь нэлээн ангилж төрөлжүүлж үзье. Бид удирдлагын зөвлөлийн хурлаараа энийг хэлэлцээд, энэ дээр үүрэг даалгаврууд өгөгдсөн.

Ялангуяа иргэдээс ирж байгаа энэ саналуудыг бүүр нээлттэй авдаг энэ систем рүү шилжье. Тэгээд энэ дээрээ таны яг түрүүний хэлдгээр системийн шинж чанартай байдлаар ер нь их том зургаар нь харж асуудлуудаа шийдье. Зөвхөн ингээд нэг гал унтраах байдлаар биш гэж явъя гэдэг энэ тохиролцоонд хүрээд, бид энэ чиглэлээрээ үүрэг даалгавруудаа өгсөн. Сайдын зүгээс энэ дээр нэг нээлттэй ийм системүүдийг хийе гэдэг дээр ярилцсан байж байгаа.

2 дахь асуудалтай холбоотой энэ хөдөөгийн, энэ хөрөнгө оруулалттай холбоотой юмнууд дээр энэ жилийн хувьд та бүхэн маань мэдэж байгаа байх. Өнгөрсөн онд бид энэ хөрөнгө оруулалтын ажлууд тасарч, мөнгө буцаж татагдсан асуудлууд гарсан. Энэ жил ЭМЯ энэ дээр онцгойлон анхаарч төсөл, арга хэмжээнүүдийг бүгдийг нь зохион байгуулж, нийт яг төлөвлөсөн нийт арга хэмжээнүүд зохион байгуулсан. Ялангуяа энэ тоног, төхөөрөмжтэй холбоотой энэ арга хэмжээнүүд дээр энэ онд нийт 60,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээ баталсан байж байгаа. Ингээд энийг худалдан авах ажиллагаануудыг Төрийн худалдан авах үйл ажиллагааны газартай явж байгаа.

Зүгээр ер нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль шинэчлэн батлагдсан. Энэ хууль дээр нэлээн нарийн зохицуулалтууд ороод ирсэн. Ялангуяа энэ эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн асуудлууд одоо болтол тодорхой зохицуулалтгүй ингэж явж байгаа, 27 оны 01 сарын 01-нээс хэрэгжих ёстой. Гэхдээ өнөөдөр энэ дээр бид Эмийн агентлагтай ярьж байна. Энэ шуурхай энийг хэлэлцэж, бид энэ тодорхой дараа шатны хурлуудаар оруулж ингэж явъя. Тэгэхгүй бол ирэх оноос эхлээд энэ тоног, төхөөрөмжийн хангалтын асуудлууд дээр асуудал үүсэх нь гэдэг. Тэгэхээр энэ дээр таны асуугаад байгаа тэр эрэмбэлэх асуудлууд, ялангуяа энэ эрсдэлийн зэргээр 1, 2, 3 дугаар зэрэг нөгөө аюултайгаас эхлээд ингээд энгийн гэдэг хүртэл энэ эрсдэлийн зэргүүдийг тусгачихсан энэ төслүүд нэлээн яригдаад явж байгаа. Удаа дараагийн хэлэлцүүлгүүд хийгдсэн, энэний дараа бүртгэл мэдээллийн системүүд илүү тодорхой болно. Бид орон нутаг дээр ямар тусламж, үйлчилгээ үзүүлж байна, тэнд ямар хүчин чадлын тоног, төхөөрөмж байх вэ гэдгээ илүү тодорхой харж чадна.

Тэгэхгүй бол одоо ингэж байгаа нөхцөл байдлаасаа илүү давсан, энэ тусламж, үйлчилгээг цар хүрээнээсээ илүү авсан ийм үр ашиггүй хөрөнгө оруулалтууд явдаг. Ялангуяа сүүлийн үед энэ бүрэн автомат технологид шилжсэнтэй холбоотой урсгал зардлууд дагаж нэмэгдээд байгаа. Тэгээд энийг бид онцгойлон анхаарч, энэ дээрээ нэлээн ийм ончтой шийдлийг гаргаж ажиллана гэдэг байдлаар зорьж ажиллаж байгаа.

О.Номинчимэг: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Хариулттай ялангуяа тэр сүүлийн хэсгүүдтэй яг үнэн, яг бодитой, тэгээд тэр хаалттай системүүд энэ тэр гээд бүүр яг л миний ярьдаг, боддог, зовдог юмнууд дээр санал бүтэн нэгдэж байна. Юу тэр нөгөө өндөр туулал ихтэй машин гэж ярьдаг билүү, хөдөө орон нутагт хуваарилдаг тийм туулах чадвар өндөртэй тэрэн дээр, нэг жишээлбэл хөөцөлдөө сайтайнуудад нь машин унаатай болоод, үгүйнүүд нь хаягдаад яваад байгаа юм байна уу? Энэ дээр технологийн үнэлгээ ч юм уу, яг хүн амын бодит хэрэгцээ дээр тулгуурласан байдлаар та хэд энэ асуудлаа шийдэх гэж байна уу гэдэг төлөвлөгөөгөө ч юм уу, хэрвээ юм байхгүй байгаа бол?

Тэгээд үлдсэн наадад чинь дахиад нэг тодруулах боломжтой билүү? Тэгвэл үргэлжлүүлээд минутаа авчихъя бараг. Энэ 2 асуулт байгаа нь 1 дүгээрт энэ ЭМД-ын сангийн тогтолцоо, ингээд зарцуулалтын ил тод байдалд иргэд маш их санаа зовж, зөвхөн иргэд ч биш, гишүүд. Эдгээр дээр одоо нэг асуудал байгаа нь энэ сангийн зарцуулалтын мэдээлэл нь олон нийтэд хэр зэрэг хүрч чадаж байгаа вэ? Энийг ЭМД-ын ерөнхий.../минут дуусав/

О.Номинчимэг: Ганмаа гишүүнд нэмэлт 1 минут тодруулга.

Д.Ганмаа: Иргэдэд даатгалынхаа хамрах хүрээг мэдэхгүй байна гэдэг дээр яг ямар байдлаар хариултыг илүү олон нийтийг мэдээлэлжүүлэх ойлгуулах, эрүүл мэндийн байгууллагууд хүртэл энд мэдэх, мэдэхгүй асуудлууд зөндөө гараад байна л даа. Эв санааны нэгдэл гэдгийг тооцохгүйгээр зөвхөн мөнгө санхүү, даатгалаа төлж байгаа хүмүүст тусламж, үйлчилгээ үзүүлье гэдэг хүртэл яриа хүртэл яригдаж байгаа шүү дээ. Эдгээр дээр ЭМЯ-наас, даатгалын газраас олон нийтэд мэдээлэлжүүлэх, зөв ойлголт өгөх, нээлттэй, ил тод тайлагнах механизмыг бий болгох тал дээр та хэд ямар ажил төлөвлөж, бодож боловсруулж байгаа вэ гэдэг нэг асуулт байна? Тэгээд тэр эмийн бүртгэлтэй холбоотой асуудал уул нь надад байна. Яах вэ цаг гарвал асууя даа.

О.Номинчимэг: 6 номер.

Н.Эрдэнэбаяр: Ганмаа гишүүний асуултад нэмж хариулъя. Туулах чадвар өндөртэй машинуудыг бид яг хэрэгцээг нь тооцох энэ асуудлуудыг би нэлээн эргэж ярилцъя гэж бодоод байна. Энэ дээр яг тавигдаж байгаа шалгуур үзүүлэлтүүд нь юу байгаад байна, зөвхөн хүсэлтээрээ яваад байна уу, эсхүл үнэхээр тооцооллоо хийж, яг зөв газарт нь, хэрэгтэй хүчин чадалтай ийм өндөр туулах чадвар бүхий машинаа өгч байна уу гэдэг дээр бид эргэж би энийг нэлээн сайн анхаарч, танд тодруулаад дараа нь албан байдлаар мэдэгдье гэж ингэж бодож байна.

ЭМД-ын сангийн асуудал нэлээн анхаарал татаж байгаа. Энэ дээр ойрын үед бид сая сүүлийн 2 долоо хоног бүтэн сууж байгаа. Яг энэ сангийн үр ашгийг бид яаж дээшлүүлэх юм бэ, яаж илүү оновчтой, түрүүний хэлж байгаа тэр эв санааны нэгдэл

гэдэг энэ зарчмууд, энэ сангийнхаа яг үнэн, бодит энэ зүйл рүүгээ яаж явах вэ гэдэг дээр нэлээн анхаарч байгаа. Энэ дээр бид олон улсад ажиллаж байсан ийм туршлагатай зөвлөхүүдийг авч, тэд нараас зөвлөгөө зөвлөмжүүдийг авч байна. Дээрээс.../минут дуусав/

О.Номинчимэг: Гүйцээгээд хариулъя, 1 минут 6 номер.

Н.Эрдэнэбаяр: Яг энэ сангийн тооцооллуудаа хийгээд байгаа, сан маань өөрөө нэлээн хязгаарлагдмал байгаа. Тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээ маш өндөр байгаад байгаа. Тэгээд энийгээ бид нэлээн олон тооцооллууд хийж байна. Энэ дээр эмтэй холбоотой тооцооллууд, ялангуяа ЭМД-аас хөнгөлөлт үзүүлж байгаа эмүүдтэй холбоотой тооцооллууд дээр ажиллаж, ямар боломжууд байна вэ гэдэг дээр энэ дээр зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтуудыг шинэчилж явж байна. Хөнгөлөлттэй олгох эмүүдийн жагсаалтуудаа шинэчилж байна. Яг энэ тооцоолол дээр өдөр болгон ажиллаж байгаа. Тэгээд маш ойрын хугацаанд бид ингэж энэ дээр мэдээллүүд хийнэ.

2 дугаарт нь яах вэ гэхээр бид энэ асуудлууд ингээд тодорхой болоод ирсний дараа эрүүл мэндийн байгууллагууддаа болон ард иргэддээ ойлгомжтой байдлаар мэдээлэх энэ мэдээллүүдийг явна. Өнөөдөр манай ЭМД-ын ерөнхий газраас сүүлийн үед яг энэ орчин цагийн энэ юунууд дээр арга хэрэгслүүдийг ашиглаад мэдээллүүдээ түгээх юмнуудыг эрчимжүүлж байгаа. Ялангуяа фейсбүүкээр гэдэг юм уу, ийм зорилтот бүлгүүд рүү чиглэсэн мэдээллүүдийг бид явуулж эхэлсэн байгаа.

О.Номинчимэг: Дараагийнх Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн асуулт асууя.

П.Мөнхтулга: Өргөдөл, гомдлуудаа бид цуглуулсан чинь Монгол даяар эмийн асуудал нэгд орчихлоо гэхээр итгэхэд жоохон хэцүү л байна. Яг 126 гишүүдээс 78 нь тойрогт дэвшсэн, бүх хөдөө орон нутгийн тойрогт дэвшсэн гишүүдэд 2 сонгууль дамнуулж иргэд маань ганцхан л юм хэлээд байгаа. Тэр нь энэ арьс ширний үйлдвэр, энэ малын гаралтай түүхий эдийг бид нэг боловсруулчих юм сан, бүгдийг нь жалганд хаяад байна гээд. Ахмадууд Монгол Улсад 250 гаруй мянган малчин өрх байгаа. Хэдэн хүн эм дээр гомдоллож явдгийг би мэдэхгүй байна. Тийм олон 200, 300 мянгаараа өвчин тусчхаад, эмээ авах гээд яваад, барахгүй байгаа, тэгээд бүгдээрээ нийлж гомдол бичээд байгаа гэж би бодохгүй байна.

Малчид өглөө болгон энийг асууж, гишүүд рүүгээ ярьж байгаа. Дараа нь ахмадууд байна, яг тойргоос байнга ярьж байгаа хүмүүсийг хэлж байна. Тэтгэвэр 600 мянга байсан, одоо 700 хүрэх гэж байх шиг байна. Тэгээд юмны үнэ хэтэрхий өсчихлөө. Түлш 6 мянга гарах гэж байна, тэтгэвэр ийм байна гээд ингээд өдөр болгон шахуу л ярьж байна. Тэгээд хүсэлт ч бичиж байна, гараар зайлуул зарим нь биччихсэн байх юм, зарим нь компьютероор ач, зээ нараа гуйж байгаад шивүүлээд л ирэх юм. Тэгээд яаж ч бодсон бодит амьдрал дээрх байдал, тэгээд одоо байгаа тайлан 2-ыг харахлаар зүгээр миний мэдрэмжээр л лав зөрөөд байна. Би нөгөө та нарын багт орж, тоон нэгтгэл дээр нь суугаагүй учраас. Тэгэхээр энэ дээр та хэд маань яг ирж байгаа сувагчлалаа, тоо баримтуудаа яг зөв гэдэгтээ хэр итгэлтэй байгаа вэ?

Өнөөдөр яг хангайн бүсийн тойрог дээр л лав энэ 2 асуудал хамгийн өндөр байна шүү. Бусад бүсүүдээс асуухад ер нь хүн амынхаа тоог бодсон ч гэсэн ийм

байна шүү. Би лав 300 мянган малчдаас илүү, 300 мянган хүн эмийн хөнгөлөлт эдлэх гээд гомдоод яваад байна гэдэгт би итгэхгүй байна. Тэгэхээр энэ тэтгэврийн асуудал, малчны түүхий эдийг боловсруулах асуудал яг энэ өргөдлийн дүн нэгтгэл дээр чинь хэдэд яваа юм бэ? Энийг асуугаад, хариултаа авчхаад, тодруулъя.

О.Номинчимэг: Хэн хариулах вэ гишүүний асуултад? Хэрэг эрхлэхийн сайд, Энхбаяр сайдаа хэн хариулах вэ? Тэтгэврийн асуудал, малчдын мал ширний үнэлгээний асуудал өргөдөл, гомдлын асуудлууд ямар хэмжээнд, хэн байна, хаана байна гэдэг асуултад. Тэтгэврийн. Мөнхзул дарга байгаа юм байна тийм үү? Мөнхзул дарга микрофонтой газар эхлээд очоод суугаадах. 6 номер Мөнхзул ТНБД.

Л.Мөнхзул: Гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ТНБД Мөнхзул. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон НДЕГ тэтгэвэр авагчдаас тэтгэвэр нэмэгдүүлэх асуудлаар өргөдлүүд олноор ирж байгаа. 2024, 2025 онд 26 оны төсвийг хэлэлцэх үеэр тэтгэврийг нэмэгдүүлэх асуудлаар Төсвийн байнгын хороо, холбогдох Байнгын хороонууд дээр Өргөдлийн байнгын хороон дээр ч гэсэн ажлын хэсэг гарч ажилласан. Үүнтэй холбогдолтойгоор тэтгэврийг нэмэгдүүлэхэд шаардлагатай нэмэгдлийн хэмжээг нийгмийн даатгалын санд дундаж тэтгэврийг 8,6 хувиар нэмэгдүүлэхээр холбогдох хөрөнгийг УИХ-аас баталж өгсөн. Энэ 8,6 хувь гэдэг маань яаж гарч ирсэн юм гэхээр 26 оны хүлээгдэж буй инфляцын түвшнээр нэмэгдүүлэхээр ингэж төсөв батлагдсан. Энэ төсөвт багтаан тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн. Дунджаар тэтгэврийн хэмжээ 9 хувиар нэмэгдсэн. Ингэснээрээ дундаж тэтгэврийн хэмжээ 930 мянган төгрөгт хүрсэн байна. 2025 онд дундаж тэтгэврийн хэмжээ 850 мянган төгрөг байсан. Тэтгэвэр авагчдын тоо 525 мянга орчим хүн байна.

2 төрлийн шинж чанартай өргөдлүүд ирж байна. Тэтгэврийн доод хэмжээ авч байгаа тэтгэвэр авагчид тэтгэврийн хэмжээг 1 саяас 1 сая 500 мянган төгрөг болгож өгөөч гэсэн ийм хүсэлт ирж байна. Мөн түүнчлэн тэтгэвэр авагчдын бас тодорхой хэсгээс итгэлцүүрийн 2023 онд итгэлцүүрийг шинэчлэн тогтоохдоо 2013 оны хүртэлх цалингийн дээд хязгаарыг 1 сая 404 мянгаар хязгаарласан, энэ хязгаарыг илүү 2023, 2024 оны үнэ ханшид нийцүүлэн өсгөж өгөөч гэсэн ийм 2 төрлийн шинж чанартай өргөдлүүд ирж байгаа. Тэгээд энэ өргөдлийн асуудлаар Рэгдэл гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг Өргөдлийн байнгын хорооны дэргэд ажиллаж байна.

О.Номинчимэг: Дараагийн асуулт нь хэнээс, нөгөө арьс ширнийхээ юу Болорчулуун дарга хариулах юм уу Хүнс, хөдөө аж ахуйн яам. Мөнхтулга гишүүн нэмж тодруулъя.

П.Мөнхтулга: Тэгэхээр яах вэ өнөөдөр та хэд маань яг бэлэн хариулах тоогүй байх шиг байна л даа. Тэгээд дашбоард дээр бид мэдээллээ ингээд бодитой харж байж зөв ажил хийх байх. Тэгэхээр тоо маань нийт ахмадуудын тэтгэврээ нэмүүлэх өргөдөл, гомдлоос илүүтэйгээр эмийн өргөдөл, гомдол даваад явчхаж байна гэдэгт ямар ч эрүүл ухаантай хүн итгэхэд хэцүү байна. Тэгэхээр бид мэдээллээ яаж цуглуулаад байна, яг бодит, одоо бид анхаарах ёсгүй эрэмбийн доор байгаа зүйл дээр илүү анхаараад явчих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ хэдүүлээ аягүй цэгцтэй мэдээжийн хэрэг шинэ ЗГ бүрдээд шинэ бодлогоор ажиллах гээд л зүтгэж байгаа байх. Тэгэхээр энийгээ хэдүүлээ нөгөө оношоо зөв тогтоочихвол эмчилгээгээ зөв хийчих байх. Цаашдаа энэ мэдээллүүд дээрээ зөв сувгаар, зөв мэдээллээ, зөв эрэмбэ.../минут дуусав/

О.Номинчимэг: Санал юм уу? Баярлалаа. Би бас хэдэн асуулт асууя гэж бодож байна. 1 дүгээрт яах вэ сая Мөнхтулга гишүүн хэлж байна. Энэ нөгөө оношоо та нар зөв тавьж чадаж байна уу тоон мэдээлэл гэдэг дээр? Одоо 11 11 төв бол ЗГХЭГ-ын доор байгаа гэж ойлгож байгаа. Эсвэл Ерөнхий сайдын доор уу тийм ээ? Тэгтэл Хяналт хэрэгжүүлэх газар маань Эдийн засаг, хөгжлийн яамны доор байгаа. Тэгээд Хяналт хэрэгжүүлэх газар өөрөө ЗГ-ын, бодвол 11 11-ээс гарсан өргөдөл, гомдлуудыг салбарын харьяалах яамнуудад нь өгч шийдүүлж байгаа байх. Энийг нь хяналт тавьдаг нь Хяналт хэрэгжүүлэх газар гэж биелэлт нь яаж байна гэдэг нь тэр гэж ойлгоод байгаа. Тэгэхээр энэ нөгөө 11 11 дээр ирж байгаа өргөдөл, гомдлын агуулга, цаашаа яаж байна гэдэг дээр Хяналт хэрэгжүүлэх газар маань өөр яамны доор байгаа болохоор энийгээ бүтэн зургаар нь авч харж чадаж байна уу 1 дүгээрт? Энэ чинь уг нь бол 11 11 дээр байхад яг ЗГ төв Хэрэг эрхлэхээсээ энийгээ хянаад, яаж байна, ийж байна гэдгээ уг нь явдаг байсан. Одоо ингээд 2 тусдаа болчихоор бүтэц, зохион байгуулалтын хувьд та хэд маань тоогоо нэгтгэхэд хүндрэл гарч байгаа юм байна уу гэдэг асуудал байна.

2 дугаарт манай Өргөдлийн байнгын хороон дээр ирээд, та бүхэнд шилжүүлж байгаа олон өргөдөл байгаа. Нэгийг нь сая Мөнхтулга гишүүн хөндөж байна. Ихэнх нь тэтгэвэртэй холбоотой асуудал байгаа. Ялангуяа сая Мөнхзул даргын хэлдэг тэтгэврийн итгэлцүүрийг тогтоосонтой холбоотойгоор хохирсон ахмадуудын маань хүсэлт байгаа. Рэгдэл гишүүнээр ажлын хэсэг оны өмнө бид байгуулсан. Тэгээд энэ дээр асуудлуудыг нь шийдье, итгэлцүүрийн энэ доор үлдчихсэн энэ доод хэмжээнд нь байгаа асуудлуудаа бид харья гээд ажлын хэсэг байгуултал бид тэр ажлын хэсгийнх нь санал, дүгнэлтээ сонсьё гэхээр яамнаас мэдээлэл өгнө гэххээд өгөхгүй байна гээд 2, 3 сар болж байгаа байхгүй юу. Тэгсэн мөртөө саяхан сайд маань итгэлцүүрээ бид шинэчилнэ, энийгээ шинэчлэхээр болсон, цалингийнхаа асуудлыг шинэчилнэ гээд бодлогоо тэнд яриад явж байгаа юм.

Тэгээд ингээд мэдээж сайд бодлого нь гараад, тэр тооцооллоор нь гараад л тэр үгийг хэлж байгаа байлгүй дээ. Тэгээд яамныхан маань яагаад тэр Улсын Их Хурлын ажлын хэсэг, Рэгдэл гишүүний ажлын хэсэг хүсээд байгаа итгэлцүүрийн тэр тооцооллыг өгөхгүй байгаа юм бэ? Яагаад энэ Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны ажлын хэсгийн ажилд ийм хойрго хандаад байна вэ, та нар энэ мэдээллээ өгсөн үү? Би долоо хоног болгон Рэгдэл гишүүнийг тэр асуудлаа олон ахмадууд хандсан энэ тэтгэврийн асуудлынхаа ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсоод, шийдлээ гаргая гээд шахаад байдаг. Яамнаас мэдээллээ өгөхгүй байна гэдэг юм байгаад байгаа юм. Энэ дээр хариулт өгнө үү?

2 дугаарт энэ та бүхний танилцуулсан мэдээллийг харахаар ингээд шийдвэрлэлтийн хувь гэхээр маш өндөр байгаа юм л даа. Энэ тэгээд Улсын Их Хурлын дарга, гишүүд, Байнгын хорооноос нэлээн удаан хугацаанд буюу түрүү жилийн 6 сарын 20-ноос ирсэн мэдээлэл дээр үндэслэсэн юм шиг байгаа юм. Гэхдээ Хэрэг эрхлэх газар маань жишээ нь нийт 40 өргөдөл ирээд, шийдвэрлэсэн нь 20, шилжүүлсэн нь 19 гээд шийдвэрлэлтээ 97,5 хувиар дүгнэж байгаа юм. Шилжүүлснийгээ бол шийдвэрлэсэн гээд үзчихэж байгаа юм шиг байна. Тэгээд тэрэнтэй адилхан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч гэсэн шилжүүлэхгүйгээр бол ингээд 81,8 гэж байгаа юм. Би бол манай дээр ирсэн ахмадуудын энэ өргөдөл маш олон тооны шүү дээ.

Тэгэхээр энэ тоонд бол энэ ороогүй, ялангуяа энэ шийдвэрлэлтийн хувь дээр бол ингэж тооцох нь хэр зохистой юм бол ингээд гайхаад сууж байна л даа. Тэгээд

та бүхэнд бид бол яг нарийн нөгөө нэг мэдээллүүдээ өгсөн. Яг энэ иргэний өргөдөл та бүхэн дээр яаж шийдэгдэж байна гээд. Тэгээд бөглүүлээд ингээд ЗГ-ын Хэрэг эрхлэхээс бөглөөд ирсэн нь байгаа юм. Аль нэг сард өгсөн иргэний өргөдөл байгаа юм, бас л тэтгэвэртэй холбоотой. Бас ингээд л ажиллаж байх хугацаандаа сүүлийн 1, 2, 3 жилд нь төрийн байгууллагын буруу шийдвэрээс болоод хэдэн сар завсардчихсан. Тэгсэн нөгөө 36 сарынхаа тэтгэврийг өгөөгүй асуудал байгаад байгаа. Манай Байнгын хороон дээр 2025 оны 12 сард ирээд, 01 сарын 12-нд ЗГХЭГ шилжүүлсэн. Тэгсэн чинь 01 сарын 28-нд нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв чиглэл өгөөд гээд. Тэгээд 01 сарын 28-наас хойш тэгвэл энэ асуудал шийдэгдсэн юм уу? Ингээд шилжүүлчихээрээ шийдчихсэн гэж хэлж болохгүй биз дээ. Энэ бол шийдэл биш байхгүй юу. Нэг, ЗГ гэдэг чинь нэг л бүхэл бид гүйцэтгэх засаглал гэж харж байгаа. Нэг Хэрэг эрхлэхээсээ нэг яамандаа шилжүүлээд, дахиад энэ чинь юу болж байна гээд үнэхээр үр дүн гарч шийдвэрлэж байгаа хариу ерөөсөө байхгүй, шилжүүлчихсэн гээд л орхичхож байгаа юм. Тэгээд энийгээ шийдвэрлэсэнээр гээд.

Тэгээд 01 сарын 28-наас хойш Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас Батмөнх гээд иргэний асуудал байна л даа. Ямар хариу өгсөн юм бэ, яаж шийдсэн юм бэ, арга гаргалгаа нь юу байгаа юм бэ, хууль, эрх зүйн хүрээнд, ямар ч хариу байхгүй. Энэ дээрээ ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх агентлаг энэ өргөдөл, гомдлыг шийдвэрлэж байна гэж үзэж байгаа юм уу, үзээд энийгээ тэгээд шийдвэрлэсэн гэдэг тоондоо оруулчхаж байгаа юм уу? Ингэж хянана гэвэл энэ хяналт биш шүү дээ. Нэг их өндөр, өндөр хэрэгжилтийн тоо яриад байдаг, яг иргэндээ очиж энийгээ хэрэгжиж байгаа асуудал нь бол миний харж байгаагаар жишээ нь манай Өргөдлийн байнгын хорооноос шилжүүлсэн 23 өргөдөл дээр харж байхад байхгүй л байгаа харагдаад байна. Энэ дээр та бүхэн яаж уялдаж ажиллаж байна гэдэг дээр хариу өгмөөр байна.

3-д нь орон сууц захиалгын залилантай холбоотой кейсүүд манай дээр маш их ирсэн. Иргэдийн өргөдөл маш их ирээд, бид хууль санаачлах ёстой юм байна гээд. Энхбаяр сайд бол яг Хууль зүйн сайд байхдаа энэ дээр маш санаачилгатай ажиллаад, Хууль зүйн яаман дээр энэ хуулийг боловсруулсан. Энэ хэзээ орж ирэх гэж байна вэ? Одоо ингээд өргөдөл гаргагчид маань энэ асуудал юу болж байна, бид ингээд хохироод үлдэж байна гэдэг асуудлуудыг яриад, бид ЗГХЭГ, Барилгын яам, Хууль зүйн яам руу та бүхэн нэг хамтарсан ажлын хэсэг гаргаач. Цагдаа нь болохоор ийм асуудал яваад ирэхээр наадах чинь иргэний хэрэг байна, залилан биш байна гээд ингээд явуулчихдаг. Хууль шүүхийн байгууллагаар энийгээ шийдвэрлэх боломж нь хомсдоод, цагдаагаасаа буцдаг хэргүүд байна. Цагдаагаасаа цаашаа явсан ч гэсэн энэ хэргүүд нь удаашралтай ийм асуудлууд байна гэж байгаа юм. Тэгээд энэ дээр нэг хамтарсан ажлын хэсэг Хэрэг эрхлэх, Барилгын яам, Хууль зүйн яам хамтдаа гаргаад, энэ хохирсон иргэдийнхээ асуудлыг нэг шийдвэрлэхгүй бол нэлээн гадаа жагсаал ч гэсэн хийж байгаа асуудал байна лээ. Өргөдлийн байнгын хороон дээр олон өргөдөл ирсэн болохоор бүгдийг нь бид та бүхэндээ хүргүүлсэн байгаа юм. Энэ асуудал ямар үе шаттай байгаа вэ гэдгийг Хэрэг эрхлэхийн дарга хариул өгөөч гэж хүсэж байна. Хэн эхэлж хариулах вэ? Гэр бүл, хөгжлийн яам, Хэрэг эрхлэх, Хяналт хэрэгжүүлэх газар. 4 номер нэрээ хэлээд, хариулаарай.

Ч.Бат-Эрдэнэ: ЗГХЭГ, ХШҮДАГ-ын дарга Бат-Эрдэнэ. Номинчимэг гишүүний асуултад хариулъя. ЗГХЭГ-аас иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх энэ хууль, эрх зүйн орчны хүрээнд төрийн

захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагуудын хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, удирдах ийм хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй. Энэ хүрээндээ ЗГ-ын хуралдаанаар хагас, бүтэн жилээр энэ улсын хэмжээний өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дүн мэдээг авч хэлэлцэж байгаа.

Хагас жилээр бид энэ улсын хэмжээний дүн мэдээгээ ЗГ-ын хуралдаанд танилцуулаад ингээд шийдвэрлэсэн. Энэ дээр 3 асуудал яригдсан байж байгаа. Сая гишүүний хэлдгээр хамгийн чухал асуудал энэ Өргөдөл, гомдлын хууль маань батлагдаад хэрэгжиж багагүй хугацаа өнгөрчихсөн. Тэгээд энэ хуулийг яаралтай шинэчилж, энэ доторх байгаа зохицуулалтуудаа эргэж харахгүй бол нэлээн өнөөгийн нийгэмд зохицуулалт нь бол шаардлага хангахгүй байна гэсэн ийм асуудал яригдсан. Ингээд ХЗДХЯ-н дээр энэ хуулийг шинэчилж боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Хууль зүйн үндэсний хүрээлэнд судалгаа хийгдээд явж байгаа.

Гишүүний хэлсэнчлэн сая энэ шилжүүлээд байгаа асуудлыг бид яах юм бэ гэдэг энэ асуудал. Яг чиг үүргийнхээ дагуу шийдвэрлээд байгаа асуудал дээр яах юм бэ гэдэг, яаж хяналт тавих юм бэ гэдгийг бид илүү анхаарч үзэж байгаа юм. Ингээд жишээлбэл 2025 оны жилийн эцсийн байдлаар байдлаар 321 мянган өргөдөл байгаа юм. Энэ дотор бол давхардлууд маш их байна. Сүүлийн үед иргэд нэг асуудлаараа яг тухайн асуудлыг хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд шийдэхээр эрх бүхий байгууллагад хандах энэ асуудал гэхээсээ илүү бүх шатны байгууллагуудад энэ өргөдөл, гомдлоо гаргачихдаг. Жишээлэхэд хамгийн сүүлийн жишээ бол энэ Боловсролын зээлийн сантай холбоотой жишээ байж байгаа юм. Ерөнхий сайдад хандаж байна, Хэрэг эрхлэхийн сайдад дарга, ЗГ-ын Хэрэг эрхлэхийн сайдад хандаж байна, мөн дотоод нэгжүүдэд хандаж байна, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газарт хандаж байна, салбарын яамд хандаж байна, Төрийн албаны зөвлөлд хандаж байна, Хүний эрхийн Үндэсний Комисст хандаж байна гээд нэг ижил агуулгатай өргөдлийг төрийн бүх байгууллагуудад зэрэг ингэж бичиж өгдөг энэ асуудлууд байгаа. Энэнээс шалтгаалаад бид энэ өргөдөл, гомдлын нэгдсэн цахим систем дээрээ энэ агуулга давхардаад байгаа асуудлуудыг тогтооё гээд энэ ажлууд эхэлчихсэн. Төрийн 580 гаруй байгууллагыг холбочихсон ингээд явж байгаа. Энэ 11 сараас эхэлсэн ажил.

Энэний дараа бид төрийн бүх байгууллагууд, дээр нь төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудыг холбож аваад, эхлээд бид энэ өргөдөл, гомдлынхоо энэ давхардлыг ялгая. Дээр нь Өргөдөл, гомдлын хуульд заасан тэр өргөдөл, гомдол гээд тийм ээ, санал, мэдэгдэл энэ агуулгууд чиглэлээр нь бол эд нарыгаа ялгадаг болъё гэж байгаа. Дараа нь яг шийдэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд нь энэ өргөдлөө шийдэж байгаа юм уу гэдэг дээр хяналт тавья гэдэг. Дээрээс нь бид энэ хууль, эрх зүйн орчныг яаралтай шинэчлээд боловсронгуй болгоё гэдэг ийм 3 үндсэн чиглэлээр үүрэг өгөгдөөд, ингээд ажиллаж байгаа. Сая сайдын танилцуулгад гарсан энэ системийн ашиглалтууд нь бол ингээд байгууллагуудаа холбоод эхэлчихсэн. Хуулийн төсөл боловсруулах судалгаа, шинжилгээний ажлууд нь ингээд явж байгаа.

Бид энэ чиг үүргийн дагуу очиж, тодорхой байгууллагууд дээр сая хагас жилээр хангалтгүй үнэлгээ авсан 1 яам, 1 агентлаг, 1 аймаг дээр очиж, бид яг энэ өргөдөл, гомдлын шийдвэрлэлт бодит байдал дээр хуулийн дагуу явж байна уу, үгүй юү гэдэг дээр хяналт шалгалтаа хийгээд, ингээд энэнийхээ дагуу тодорхой арга зүй,

зөвлөн туслах энэ ажлуудыг хийе гэсэн ийм чиглэлүүд дээр Хэрэг эрхлэх газар дээр ажиллаад явж байгаа. Мөн бид бүхэн Өргөдлийн байнгын хорооноос зөвхөн Хэрэг эрхлэх газарт ирүүлсэн 23 өргөдөл, гомдол байж байгаа. Энэнийхээ.../минут дуусав/

О.Номинчимэг: 5 номер уу? Мөнхзул дарга тэр итгэлцүүртэй холбоотой тооцооллыг ажлын хэсэгт хэзээ гаргаж өгөхөөр байна гэдэг дээр.

Л.Мөнхзул: Гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул. Рэгдэл гишүүний ажлын хэсэг хэд хэдэн удаа хуралдсан. Энэ ажлын хэсэгт бол манай яам болон НДЕГ-ын холбогдох албан тушаалтнууд оролцож ажилласан. Ингээд тооцооллын хувилбарууд дээр ажлын хэсгийн хүрээнд хэд хэдэн хувилбараар ярьсан. Ажлын даалгаврын өгөгдлийн хүрээнд даатгуулагч тус бүрээр тэтгэврийн бодолтыг дахин хийдэг, тодорхой бааз дээр хугацаа шаардсан. Үүний дараа мэдээж хэрэг бодлогын хувилбаруудыг сайдтай зөвшилцөн, ингээд НДЕГ болон яам нягтлаад хүргүүлдэг. Албан бичгээр хүргүүлсэн байна. Өргөдлийн байнгын хорооны референтэд хүлээлгэж өгсөн байна. Хувийг танд бас явуулъя. Тооцоолол хүргэсэн. Өнөөдөр Эрдэнэбат гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг дээр ахмад настны төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг хуралдсан. Энэ ажлын хэсгийн хурал дээр мөн уг тооцоолол болон шаардагдах хөрөнгийн талаар танилцуулга хий гэсэн учраас яамнаас холбогдох танилцуулгыг.../минут дуусав/

О.Номинчимэг: Тэр түрүүний хариулт дээр шийдвэрлэлтийнхээ хувийг та бүхэн маань тэр иргэндээ очиж байгаа хариугаар шийдэхгүй бол шилжүүлснийг та бүхэн шийдвэрлэчихсэн гээд байвал энэ чинь ийм хий хоосон тоо гараад байна шүү дээ. Иргэндээ ерөөсөө ингээд 2, 3 сар болж байхад, зарим асуудал дээр үнэхээр 30 хоног үнэхээр хангалтгүй гэдгийг нь мэдэж байгаа бид. Тийм учраас хууль шинэчлэх асуудал бол зөв, 95 оны хуулиа бид орчин цагийн нөхцөл байдалдаа тааруулж шинэчлэх нь зөв. Гэхдээ та бүхэн тэр иргэндээ энэ асуудлыг нь яаж шийдэж байна, шийдэх боломжтой байна уу, зарим үед шийдэх боломжгүй ч өргөдөл, саналууд ирдэг. Энийг нь иргэндээ хүргэж байгаагаараа энэ шийдвэрлэлтийнхээ хувийг тооцохгүй бол бие биедээ шийдсэнээрээ хувь тооцоод байвал ингээд манайд ирсэн, биднээс явуулсан өргөдөл дээр ямар үйл явц явсан байна гэхээр ингээд нэг сараас хойш байхгүй асуудлууд байгаад байгаа. Тэр иргэн ерөөсөө хариугаа аваагүй байгаа шүү дээ. Энийг бас та бүхэн маань анхаармаар байна.

Энхбаяр сайд орон сууц захиалгын юутай ажлын хэсэг байгуулагдсан болов уу? Энэ дээр ямар арга хэмжээ, бодлогын арга хэмжээнүүд байна вэ, хууль нь хэзээ орж ирэхээр байна гэдэг дээр хариулт өгөөч? Хууль зүйн яам, тан руу сүүлд бид хамтарсан ажлын хэсгээ ингээд олон яамны оролцоотойгоор Барилгын яам эд нарыг оруулаад байгуулаад энэ нэг асуудлыг шийдээч гээд нэг бичиг явуулсан байгаа. 5 номер Мягмар дарга ТНБД хариулъя.

Н.Мягмар: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. ХЗДХЯ-ны ТНБД Мягмар. Орон сууцны захиалгатай холбоотой залилангийн шинжтэй гэдэг юм уу, хохирсон иргэд, захиалагч нарын асуудалтай холбоотойгоор ХЗДХЯ-наас дуусаагүй барилгатай холбоотой асуудлыг зохицуулалтыг сайжруулах зорилгоор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулаад, ЗГ-ын гишүүдээс санал аваад, санал дээрээ одоо ажиллаж байгаа. Тэгэхлээр энэ санал дээрээ ажиллаад улмаар ЗГ-ын хурлаар оруулж ирээд, шийдвэр, хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтож байна.

Ер нь бол энэ хуулийн маань гол үзэл баримтлал нь дуусаагүй барилгын захиалгыг нотариатаар гэрчлүүлээд, гэрээ хийсэн тохиолдолд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн юунд бол урьдчилсан тэмдэглэгээ хийх зохицуулалтыг илүү тодорхой болгож өгснөөрөө захиалагчид давхардсан байдлаар өөр этгээдэд.../минут дуусав/

О.Номинчимэг: Хариулах юм уу? 3 номер.

П.Батбаатар: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. 11 11 төвтэй ЗГХЭГ, ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газар хамтран ажилладаг. Бид хоорондоо уялдаа холбоогоо нэлээн нарийн ярилцаж тохиролцож, энэ мэдээллийн урсгалаа нэгтгэсэн байдаг. Ингээд өнгөрсөн хугацаанд бол 11 11 төв дээр 131555 иргэн утсаар, веб хуудсаар, имэйлээр, дуут шуудангаар, фейсбүүк, ИМонгол зэрэг сувгуудаар өргөдөл, гомдлыг хандсан байдаг.

2 дугаарт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хэрхэн ард нь шалгаж байна вэ гэдэг асуудлыг ярьж байна. Өргөдөл, гомдлын нэгдсэн систем ашиглалтад ороод 11 сараас хойш өнөөдрийн байдлаар 5300 орчим байгууллагаас 1600 орчим байгууллага бол энэ цахим системд холбогдсон байгаа. Эндээ бол нэг асуудал байгаа нь иргэний талд хэрхэн өргөдлийг шийдсэн бэ гэдэг.../минут дуусав/

О.Номинчимэг: Тэр хууль удахгүй өргөн баригдана гэж ойлголоо. Түүнээс гадна энэ нөгөө цагдаа дээр энэ хэрэг нь бүртгэгдэхгүй, иргэний хэрэг гээд гарчихдаг, иргэд өөрсдөө энийг иргэний хэргийн дагуу энийг шүүхэд хандаад явахаар үнэхээр нөгөө хүмүүс нь ийш, тийшээ явчихсан, эсвэл хүч нь хүрдэггүй асуудлууд байгаа. Энэ дээр цагдаа эд нараа оруулаад, хамтарсан ажлын хэсэг оруулаад, хэд нь үнэхээр залилангийн шинжтэй байгаа юм, ямар арга хэмжээ авч болохоор байна гэдэг дээр анхаараад өгөөч гээд энэ асуудлыг орон сууц захиалга залилантай холбоотой асуудлыг бол ЗГ-ын Хэрэг эрхлэхэд бас явуулсан байгаа. Яамнуудад ч гэсэн явуулсан байгаа. Энэ дээр ЗГ маань нэг анхаараад өгөхгүй бол олон жил үнэхээр болоод, аргаа ядсан иргэдийн асуудал олон байгаа шүү. Энэ дээр Өргөдлийн байнгын хороон дээр ч гэсэн өнгөрсөн 12, 01, 02 сард ирсэн ихэнх өргөдлүүд яг энэнтэй холбоотой өргөдлүүд байгаа учраас дараагийн юун дээр анхаараад, энэ дээр ямар арга хэмжээ авч болохоор байна гэдгийг танилцуулбал их сайн байна гэдгийг хэлмээр байна.

Ингээд асуулт асууж, хариулт авч дууссан. Танилцуулгатай холбоотой, энэ асуудалтай холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Лувсанжамц гишүүнээр тасаллаа. Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны дарга Номинчимэг гишүүнтэй адилхан саналтай байна. Шилжүүлчхээд түүнийгээ шийдчихсэн гэдэг хувиар оруулж ирэх нь зохисгүй болов уу гэж бодож байна. Тэгэхээр бүгдээрээ энэ дээрээ анхаарч ажиллая гэж бодож байна.

Дээрээс нь нэмээд удахгүй Хөгжлийн төлөвлөгөө болон өнгөрсөн жилийн төсвийн гүйцэтгэл ярина. Энэ дээр яг адилхан зарчмын байр суурьтайгаар асуултууд асууя гэж төлөвлөж байгаа учраас холбогдох байгууллагууд маань бэлтгэлтэй байгаарай гэж хүсье. Баярлалаа.

О.Номинчимэг: Үг хэлж дууслаа. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар ЗГХЭГ болон ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг хэлэлцүүлж дууслаа. Ер нь яах вэ дараа дараагийн сардаа нэг удаа бид өргөдөл, гомдолтын шийдвэрлэлт ямар байна, ямар асуудлууд байна гэдгийг та бүхнээсээ сонсоно. Тэгэхээр энэ нөхцөлд бол түрүү жилийн 7 сараас биш, яг тухайн сар сараар нь бид асуудлуудаа хараад, эрэмбэлээд, тэр тоо, дата дээр үндэслэж асуудлуудаа хэлэлцэх нь илүү оновчтой, үр дүнтэй болох байх гэж бодож байна. Тэгэхээр дараагийн сарын энэ өргөдөл, гомдлын шийдвэрлэлт дээр энэ мэдээлэл бэлтгэх ажилтнууд маань энэ дээр анхаараад өгөөрэй гэж хэлж байна, хэлэхээр байна.

16.23 цаг

Гурав.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Дараагийн асуудал, хэлэлцэх асуудал. 3.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.1-д УИХ-аас ЗГ, УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг УИХ-д ирүүлнэ гэж, 16.2-т Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ирүүлснээс хойш Тамгын газар Байнгын хорооны эрхлэх асуудал бүрээр дүн шинжилгээ хийж, танилцуулгын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж тус тус заасны дагуу 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаас Өргөдлийн байнгын хороонд танилцуулга хүргүүлэх тухай албан тоотой Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд дүн шинжилгээ хийж ирүүлснийг та бүхэн цахимаар болон шуудангаар тараасан байгаа. Энэ асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Баттөмөрийн Энхбаяр сайд ирсэн байна, ЗГХЭГ-ын ХШҮДАГ-ын дарга Ч.Бат-Эрдэнэ, ХЗДХЯ-ны ТНБД Мягмар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Мөнхзул, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД Баяраа, ЭМЯ-ны ТНБД Эрдэнэбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн /ХХААХҮЯ/-ны Бодлогын төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Боловсролын яамны Салбарын ХШҮДАГ-ын дарга Төгсбаяр, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Бадамжав, Боловсролын яамны Хоол үйлдвэрлэлтийн хэлтсийн дарга Түмэнжаргал, ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ЗГ-ын ахлах референт Цэцэг-Өлзий, ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ЗГ-ын ахлах референт Бямбадулам нар оролцож байна.

Мөн хууль, тогтоолоор чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлангийн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Эрдэнэбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Сайнхишиг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт Гоцбаяр, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын

референт Нямдэлгэр нар оролцож байна. Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Баттөмөрийн Энхбаяр таныг тайлан танилцуулахыг урьж байна.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

ЗГ-ын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын 6-д заасны дагуу ЗГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим системд хяналтад байгаа Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд хамаарах 3 хуулийн 12 заалт, Байнгын хорооны 1 тогтоолын 3 заалтын биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг танилцуулж байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 3 хуулийн 12 заалт 67,3 хувьтай, үүнээс 6 ажил 100 хувь хэрэгжсэн, хэрэгжих шатад 4, хэрэгжээгүй 2 заалт байна. Өргөдлийн байнгын хорооны 1 тогтоолын 3 заалт 100 хувь хэрэгжсэн байна.

ЗГ-ын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын 5.2-т зааснаар хуулиар эрх олгосны дагуу захиргааны акт, захиргааны хэмжээний акт батлан гаргасан эсэх тайланг хагас, бүтэн жилээр гарган холбогдох байгууллагад хүргүүлж байгаа билээ. Харин хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь тус журмын 5.3-д төрийн захиргааны төв байгууллага салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа хуулийн хэрэгжилтэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын дагуу 5 жил тутамд үр дагаврын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна гэж заасны дагуу тусдаа хууль, тогтоол, аргачлалаар хийгддэг. Тиймээс энэхүү тайланд зөвхөн хуульд заасан заалт, хэсгийн хэрэгжилтийг тайлагнаж байна.

2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн 9 заалтыг ЗГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сангийн хяналтаас хасах үндэслэлтэй гэж үзэж, Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна. Тайлан дунд хэрэгжээгүй 2 заалт нь төрийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт хангалтгүйгээс шалтгаалсан байна. Тухайлбал төрийн байгууллагуудын түвшинд хариуцлагын тогтолцоо хангалттай бүрдээгүй, салбар хоорондын ажлын уялдаа сул, олон удаагийн бүтцийн өөрчлөлт хийгдсэн, төсөв, хөрөнгө оруулалтын эрэмбэ дараалал хангалтгүй, бодлогын болон хүний нөөцийн тогтворгүй байдал зэрэг нь хууль тогтоомжийн биелэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн 2025 оны жилийн эцсийн тайланг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэнтэй холбоотойгоор ЗГ-ын гишүүд, ЗГ-ын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгасан. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг ханган, бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх. Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, иргэдийн ахуй амьдрал болон салбарын хөгжлийн үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж буйг үнэлж, тооцож ажиллах.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төслийг боловсруулахдаа зохицуулалт, утга агуулгын хувьд давхардал, хийдэл, зөрчилтэй шийдвэр гаргахгүй байх, санхүүгийн эх үүсвэрийг тусгах, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт хэрэгжихүйц

байхад анхаарах. Дижитал хяналт, их өгөгдөлд суурилсан үнэлгээ хийх, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг бодит цагт хянах, ил тод болгох чиглэлээр цахим шинэчлэл хийх санал боловсруулж танилцуулах. Мөн хууль тогтоомжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад даалгасан. Цаашид Монгол Улсын төрөөс ЗГ-ын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг эргэн харж, шинэчлэх, сайжруулах үндэслэл бий болсныг харуулж байна.

Хууль тогтоомжийн биелэлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын түвшинд ч анхаарах асуудлууд байна. Үүнд УИХ-аас гарч байгаа шийдвэрийн талаар нэгдсэн бүртгэлийн систем үүсгэж, ЗГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сантай уялдуулах, гарч байгаа шийдвэрийг шуурхай дамжуулах, хяналтад авах, Улсын Их Хурлын Байнгын хороо, гишүүдийн түвшинд шийдвэрийн хэрэгжилтийн явцыг цахим систем ашиглан улирал тутам танилцах боломжтой болох, УИХ-аас баталсан хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил болон тухайн жилдээ бүрэн хэрэгжсэн, бусад шалтгаанаар хяналтаас хасуулах шийдвэр, заалтын талаар ЗГ-тай тогтмол хамтарч ажиллах. Хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны шийдвэр ЗГ-ын бодлогын баримт бичигт заасан зарим заалт агуулгын хувьд давхцах, хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин тогтоол хэлбэрээр албажуулах зэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.1.УИХ-аас ЗГ, УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө УИХ-д ирүүлнэ гэж заасан нь цаг хугацааны хувьд үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хангалтгүй байгаа тул хугацааг уян хатан байдлаар зохицуулах. Иймд Улсын Их Хурлын бүтцийн нэгжтэй хамтран хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийж, ажлыг цаашид боловсронгуй болгох, УИХ-аас гарч байгаа шийдвэрийн биелэлт, үр дүнд байгаа хяналтыг сайжруулахыг зорьж байна.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд хамаарах хууль, тогтоолын биелэлтийг 2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийг хавсаргасан болно. Баярлалаа.

О.Номинчимэг: Энхбаяр сайдад баярлалаа. Тэгэхээр энэ удаагийн бид ЗГ-ын энэ УИХ-аас гарсан шийдвэрийн хэрэгжилтийн энэ тайланг сонсохдоо Өргөдлийн байнгын хороо өмнөх жил байгуулагдаагүй байсан учраас яг Өргөдлийн байнгын хороонд Улсын Их Хурлын тогтоолоор ч байдаг юм уу даалгасан асуудал байхгүй. Харин бид манай гишүүдийн саналаар хаврын чуулганаар хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, мэдээлэл сонсох саналуудаар бид цаглавар баталсан. Тэгээд энэтэй холбоотой асуудлаараа ЗГХЭГ-аас мэдээлэл сонсохоор цар хүрээг нь оруулсан байгаа. Цаашид өмнө дурдсанчлан бид Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулаад Байнгын хорооноос ЗГ-т чиглэл өгдөг энэ чиг үүрэг маань ороод ирвэл яг өөрсдийн эрхэлсэн, иргэдийн өргөдөл гомдлын дагуу өгсөн чиг үүргийн дагуу ЗГ-т чиг үүрэг өгөөд, энийгээ хянадаг асуудал нь яг энэ цар хүрээндээ ороод, үнэлгээ хийгдээд ирдэг ийм жишиг рүү орохоор байгаа гэдгийг тодруулж хэлье.

Тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Пунсалмаа гишүүнээр тасаллаа, 3 гишүүнээр. Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Хэдэн асуулт байгаа. Хамгийн миний анхаарал татаж байгаа Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд заасан 2 хэсгийн заалтын биелэлт нь бүүр тэг гээд гарчихсан юм байна. 2 хэсгийн заалт нь ерөөсөө огт хэрэгжээгүй, 2017 оноос хойш 8 жил уул нь болчихсон хууль батлагдсанаас хойш. Тэгээд энэ дотроос нэг нь Эхийн сүүний тэр нөөцийн банк байгуулах тухай журам нь ерөөсөө батлагдаагүй яваад байгаа юм. Энэ яагаад ингээд батлагдахгүй яваад байгаа юм бэ гэдэг нэг асуудал байгаад байна? 15.2 дугаар зүйл Амаржих газар, тасаг нярай хүүхдийн хоол тэжээлийн хэрэгцээг хангах зорилгоор эхийн сүүний нөөцийн банк байгуулж ажиллуулна гэдэг нь, тэгээд 15.3 дээр Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн батална гэдэг журам батлагдаагүй. Энэ дээр эхлээд хариултаа авчихъя, яагаад гэдэг дээр?

О.Номинчимэг: Хүнсний тухай хуулийн хэрэгжилт эхийн юутай, 5 номер ТНБД.

Н.Эрдэнэбаяр: ЭМЯ ТНБД Эрдэнэбаяр. Ганмаа гишүүний асуултад хариулъя. Тийм, энэ Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн энэ дээр 15-ын энэ 2, 3 дахь заалтуудыг бид гаргаж үзсэн байгаа. Энэ бол удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай гэдэг байдлаар бид ингэж томьёолж, энэ тайланг хүргүүлсэн. 50 хувь гэдгээр, 0, 50 хувь, 100 хувь гэсэн ийм 3 юугаар үнэлэгдэж байгаа. Энэ дээр Эхийн сүүний нөөцийн банк ажиллуулах журмын төслийг боловсруулах ажлыг ЭМЯ, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, нялхсын эрүүл мэндийн үндэсний төв 2, Өргөө, Хүрээ амаржих, Интермед эмнэлэг, НҮБ-ын хүүхдийн сангийн төлөөллийг оролцуулсан уулзалтыг 2025 оны 11 сард зохион байгуулж, журмын төслийг боловсруулаад, тэгээд яамны цахим дээрээ байршуулсан ил тод байршуулсан байгаа.

Энэ журам батлахад олон улсын зөвлөхүүдийг авч ажилласан. Ер нь зүгээр миний авсан мэдээллээр өмнө нь энэ талаар яригдаад, гэхдээ энэ дээр ингээд саналын зөрөлдөөнтэй байдлаас болоод хойшлогоод яваад байсан гэж ойлгосон. Тэгээд энд олон улсын зөвлөхүүдийг энэ дээр ажиллуулж, туслахыг, зөвлөмж авах шаардлагатай гэдэг байдлаар Эрүүл мэндийн сайдын 2026 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А77 тоот дугаар тушаалаар Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг баталсан байж байгаа. Уг тушаалын захиргааны хэм хэмжээний актыг улсын бүртгэлд бүртгүүлэхээр нөлөөллийн шинжилгээ хийж, холбогдох материалын хамт 26 оны 3 сарын 04-ний өдөр ХЗДХЯ-нд хүргүүлсэн байж байгаа. Ингээд 24-ний өдөр зохицуулах ёстой харилцааг журмаар зохицуулсан, зарим зохицуулалт нь хуульд нийцээгүй, зохицуулалт насны хязгаар тогтоох, донор эхийн сүү хэрэглэх, нярайг эрэмбэлэх зэрэг донор эх болон түүний сүүг хэрэглэх нярайн эрх зүйн суурь харилцаа хуулиар зохицуулагдаагүй байхад журамласан, журамлан тусгасан тул холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дахин боловсруулах шаардлагатай гэсэн ийм зүйл ирчихсэн байгаа. Өөрөөр хэлбэл ингээд хэрэгжилт нь 50 хувь гэдгээр ингэж явж байгаа.

О.Номинчимэг: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Энэ хуулиар хориглосон нэг хэсгүүд байгаа юм. Жишээлбэл сүүн тэжээлийн бүх төрлийн зар сурталчилгааг хориглосон гээд 10.1.1-ээс 10.1.7-гийн хооронд. Эхийн сүүтэй адилхан гэсэн агуулгатай шошго, зарыг хориглох, угж сорох,

соруулах, хөхөлт бүхий аяганы сурталчилгааг хориглох, эрүүл мэндийн ажилтанд уг бүтээгдэхүүнийг мэдэгдэж, дамжуулахыг хориглосон бүүр ийм заалтууд. Тэгээд бодит байдал дээр бас л нөгөө хэрэгжилт нь ерөөсөө байхгүй, дээрээс нь хяналт нь их хангалтгүй харагдаад байна. Нийгмийн сүлжээгээр харвал фейсбүүк, инстаграм юу ч байдаг юм сүүн тэжээлийн сурталчилгаа нэлэнхийдээ байгаа. Түүн дээр энэ импортлогч компаниудын онлайн платформоор хориглосон бүтээгдэхүүнийг бас зарагдаж байгаа нь ил тод, нээлттэй. Тэгээд 14.5, 14.6-д заасан тэр салбар зөвлөл байгуулагдаж, хяналт хийнэ гэж байгаа боловч энэ хийгдсэн эсэх нь тодорхой биш. Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулсан энэ тэр гэсэн асуудал энд ерөөсөө огт бас хариу байхгүй гэх мэтчилэн нэлээн олон асуудлууд.../минут дуусав/

О.Номинчимэг: Ганмаа гишүүн нэмэлт 1 минут.

Д.Ганмаа: Тэгээд ингээд датаг нь харахаар энэ эхийн сүүгээр хооллолтын байдал, эхийн сүү чинь юутай ч орлошгүй хүүхдийг эрүүл саруул байх, эрүүл саруул торних нөгөө даавар immunity гол нь нөхцөлдүүлдэг зүйлс байгаа шүү дээ. Гэтэл энд 2000 он гэхэд 90 хувь нь эхийн сүүгээр хооллолттой байсан бол 10 онд 66 хувь, 13 онд 47 хувь, 23 онд 50 хувь хүртэл ингээд буурчихсан. Тэгээд энэ дээр маш том эрсдэлүүд гараад байна л даа. Нөгөө сүүгээр дан 6 сар хүртэл хооллох ёстой. Тэгээгүйн уушгины хатгааны эрсдэл 30 хувь, суулгалт 50 хувиар нэмэгддэг. Эхийн сүүгээр явбал энэ эрсдэлүүдийг бууруулах боломжтой гэсэн асуудлууд байгаад байгаа. Тэгэнгүүт энэ дээр яг нөгөө хяналт хийж байгаа ажлууд 50 хувийн гэж хэлж байгаа боловч энэ дээр цаашид хийхээр хэрэгжүүлэх гэж байгаа бодлого, төлөвлөгөө юу байна вэ, энийгээ нэг хуваалцах уу?

О.Номинчимэг: 6 номер нэрээ хэлээд, гишүүний асуултад хариулъя.

Б.Янжмаа: ЭМЯ-ны Салбарын ХШҮДАГ-ын дарга Янжмаа байна. Ганмаа гишүүний асуултад хариулъя. Энэ хууль тогтоомжийн хэрэгжилтээр таны дурдсан заалтуудын яг хяналт шалгалт тавих үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь ер нь бол үнэн, бодит байдал дээр тийм байгаа. Зар сурталчилгаа дээр энэ хуулиар зааснаар Монополын эсрэг газар, түүнчлэн манай Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар хамтран хяналт тавьж байгаа. Яг ЭМЯ-ны хувьд эрүүл ахуй, эмчилгээний чанарт бол хяналтын үйл ажиллагааг ингээд хэрэгжүүлээд явж байгаа. Гэсэн хэдий ч нэгэнт хүний эрүүл мэндтэй холбоотой асуудал учраас манай яаманд өргөдөл, гомдол иргэдээс ирж байгаа мэдээллийн журмаар бид холбогдох өргөдлийг агентлаг руугаа шилжүүлээд, Монополын эсрэг газартай хамтран ажиллах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Нялх, балчир, бага насны хүүхдийн хоол, тэжээлтэй холбоотой ААН, байгууллагууд импортоор бүтээгдэхүүнийг оруулж ирэхдээ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа.../минут дуусав/

О.Номинчимэг: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Хууль тогтоомжийн биелэлтийн тухай ярьж байна. Энэ тал дээр хүнс дээр нэг асуулт байна. Өнөөдөр бид ер нь хүнснийхээ чанарыг хэрэглэгчид маань ер нь хэр сайн мэдэж байна вэ? Гадуур энэ хорт хавдар өвчлөл маш ихэссэн байж байгаа. Гэтэл бид өнөөдөр хүнснийхээ яг идэж байгаа хоол, хүнснийхээ чанарыг ер нь хэр сайн мэдэж байгаа юм гэдэг асуудал байна. Маш олон хуулиуд байгаа л даа. Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдал,

Стандартын тухай хуулиуд гээд байж байгаа. Гэхдээ бид энэ дэлгүүрээс авч байгаа бараа, бүтээгдэхүүнийхээ гарал үүслийг ч гэсэн бид мэдэж байгаа юм уу бүрэн дүүрэн? Аль малчны хотонд бэлтгэгдсэн мах, сүү юм, ямар вакцин хийлгэгччихсэн юм, ямар тээвэрлэлт, хадгалалт туулчихсан юм, тэгээд тэр маань аль цехэд үйлдвэрлэгдээд, савлагдсан юм, дэлгүүртээ хэзээ ирсэн юм энэ болгоныг болгоныг бид мөшгөх тогтолцоогоор иргэд маань бүгдийг нь ингээд хараад, бар кодоор хараад, ингээд хүнсний бүтээгдэхүүнээ хэрэглэх боломж байна уу? Энэ бол стандарт байхгүй юу.

Бид зарим газраа энэ гарал үүслийн гэрчилгээ нэхээд байдаг, зарим хэсэг дээрээ нэхдэггүй. Ингэвэл стандарт чинь мөрдөгдөхгүй байгаад байгаа юм. Тендер мөн ижилхэн шүү дээ. Тендер дээр зарим төрийн худалдан авалтын тендер дээр маш өндөр стандарт тавьчихдаг, заримд нь стандарт байдаггүй. Тэрнээс болоод энэ хоол, хүнсний аюулгүй байдал чинь алдагдаад байгаа юм. Тэгэхлээр одоо энэ гарч ирсэн 2012, 19, 17 оны энэ өөрчлөлтөөр чинь стандартын талаар, энэ лабораторийн талаар ямар өөрчлөлт оруулж ирсэн бэ? Гол нь энэ мөшгөх тогтолцоогоо бүгдийг нь нэгтгэж, нэг платформд харуулж, энийг хэрэглэгчдэд харуулахад л ерөөсөө гол утга учир байгаа байхгүй юу. Тийм их том ажил ч биш, энэ хүндрэлтэй ажил ч биш, энэ зөвхөн агентлагуудын хоорондын холбоос, нэгтгэлийн асуудал байгаад байгаа байхгүй юу. Энэ тал дээр та бүгдийн саналыг сонсьё?

О.Номинчимэг: Болорчулуун дарга ХХААХҮЯ-аас, 3 номерын микрофоны сандал дээр суугаад хариулах уу? 6 номер Болорчулуун дарга асуултад хариульъя.

Ц.Болорчулуун: ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Пунсалмаа гишүүний асуултад хариулт өгье. Тэгэхээр хүнсний аюулгүй байдал гэдэг бол хүний эрүүл мэнд, улс орон оршин тогтнох чухал зүйл. Хүнсний тухай хуулийг 2012 оны 12 сарын 20-нд анх удаа шинэчилсэн найруулгаар баталснаас хойш нийтдээ өдий хүртэл 7 удаа нэмэлт, өөрчлөлт орж явсан байдаг. Ингэж 7 удаа нэмэлт, өөрчлөлт орохдоо бол 2023 онд импортын хүнсний журмыг салгах зохицуулалтаас бусад нь бол хууль тогтоомжид нийлүүлэх замаар өөрчлөлтүүдийг оруулж явсан. Яг тухайлан Хүнсний тухай хуульд энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой энэ зохицуулалтыг бол хийж ирээгүй байгаа.

Түүнчлэн 2022 онд Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг орон даяар зарлаж, Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол батлагдаж, хүнсний хангамж, аюулгүй байдалтай холбоотой энэ тогтоолын хэрэгжилтийг хэрэгжүүлж эхлэхдээ Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, зохицуулах үйлчлэлтэй Хүнсний тухай хуулийг батлах гээд эрх зүйн орчныг боловсруулахад болон боловсронгуй болгох талаар энэ хуулиудыг шинэчлэн батлах, шинэчилсэн найруулгаар оруулах энэ зохицуулалтыг тусгаж өгсөн. Үүнтэй холбоотойгоор салбарын яамнаас Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тооцоо судалгаа, хуулийн төслийг боловсруулаад сүүлдээ гишүүдээс буюу Мандхай гишүүн Хүнсний тухай хуулийг өргөн бариад, хэлэлцүүлгийн шатад явж байгаа.

Хүнсний аюулгүй байдлын тухай хууль дээр бас гишүүн өргөн бариад, Лүндэг гишүүн өргөн бариад явж байгаа. Тэгэхээр одоо бол мэдээж энэ хүнсний, бид хүнсний хангамж, аюулгүй хангамжийн асуудал бол дотоодын үйлдвэрлэл буюу импортын хамаарал гэсэн 2 зүйлээс бүрдэж байгаа. Импортын хүнсний импортын хүнс дээр бол гаалийн байгууллага ерөнхийдөө хяналтыг тавиад явж байгаа. Дотоодын хүнс дээр мэдээж бид эрүүл, аюулгүй хүнс идэж байна уу гэдэг дээр

малчны хотноос гарч байгаа малын махнаас эхлээд мөшгөх тогтолцоог хэрэгжүүлж, хэрэглэгчийн ширээн дээр тавих хүртэлх энэ мөшгөх тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлд олон ажлуудыг хийж байгаа боловч төдийлөн 100 хувь хэрэгжиж байгаа гэдэгт, хэрэгжихгүй байгаа гэдэгтэй бол санал нэг байгаа.

Тийм учраас энэ шинээр өргөн барьж байгаа Хүнсний тухай хууль болон Хүнсний аюулгүй байдлын тухай хуульд эдгээр өөрчлөлтүүдийг зохицуулалтуудыг хийх талаар тодорхой саналуудыг тусгаад явж байгаа. Энэ хуулийн төслийг шинээр батлуулснаар бидэнд өнөөгийн нөхцөл байдалд үүсээд байгаа нөхцөл байдал дээр тодорхой алхмуудыг шийдвэрлэж ажиллах боломж нөхцөл үүснэ гэж харж байгаа. Ер нь энэ 2 хуулийг дагаад нийтдээ 27 заавар, журам, дүрэм батлагдах ёстой байсан. Үүнээс өнөөдрийн байдлаар бид 24-ийг нь батлаад, одоо хэрэгжүүлээд, тодорхой хэмжээнд хэрэгжээд явж байгаа. Тэгэхдээ хүнсний лавлагаа лаборатори гэхэд Стандартчилал, хэмжил зүйн газрын харьяанд байгаа гээд ингээд ер нь бол тогтолцооны хувьд ч гэсэн яг хүнсний аюулгүй байдлыг цогцоор нь хянаж явахад бол учир дутагдалтай зүйлүүд байгаа гэдгийг бас хэлье.

О.Номинчимэг: Пунсалмаа гишүүн тодруулъя.

Б.Пунсалмаа: Тэгэхлээр яамнаас энэ малчны хотноос яг хэрэглэгчийн хэрэглээнд ирж байгаа энэ бүтээгдэхүүний мөшгөх тогтолцоог сайжруулах энэ алхмуудыг одоо хэрэгжиж байгаа ямар зүйлүүд байна, энэ алхмуудыг бичгээр авах ийм саналтай байгаа шүү.

О.Номинчимэг: Тэгвэл Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Пунсалмаа гишүүнд энэ арга хэмжээтэй холбоотой мэдээллийг бичгээр гаргаад өгөх үү. Тэгье. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? Иргэдийн гомдол мэдээллийн сантай холбоотой тодруулах асуулт байна. 11 11 чинь 24 цаг билүү, ажлын цагаар байдаг билүү гэдгийг тодруулах гэсэн юм?

2-т гэвэл өргөдөл, гомдлын хэлбэр дээр 223 санал, 18296 гомдол яг тоогоор нь задалсан юм байна. Тэгээд энэ 18 мянган гомдлоос яг ямар төрлийн гомдлууд давамгайлж байсан юм бэ? Санал нь, 223 саналынх нь дагуу ямар төрлийн саналууд давамгайлж байсан юм бэ, энэнтэй холбоотой яг ямар, ямар үйлдэл хийгдсэн юм бол гэдгийг тодруулах гээд байгаа юм?

3 дугаарт нь болохоор миний бие өөрөө сайд нар луу иргэдээс ирсэн өргөдөл, гомдлуудыг дамжуулдаг. Гол төлөв над дээр 3 төрлийн гомдол, хүсэлт ирдэг байхгүй юу. Нэг нь болохлоор гадаадад Монголд эмчлэгдэхгүй байгаа учраас эрүүл мэндийн гацаанд орчихсон ийм хүмүүс байгаа, эмээ авч чадахгүй байна ч юм уу, эмчилгээ болохгүй байна гээд, эмчилгээгүй энэ тэр гээд, тэгээд хөгжлийн бэрхшээлтэй болчихсон, яахаа мэдэхээ байчихсан хүмүүс бол зардал мөнгөний асуудал дээр гомдол байдаг. Нэг нь болохоор орон байрны асуудал байдаг. Орох оронгүй, гадуур айлд амьдарч байна ч юм уу энэ дээр ингээд дэмжлэг үзүүлээч гэсэн асуудал байдаг. 3 дахь асуудал нь Боловсролын зээлийн сантай холбоотой асуудал байгаа. Бид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульдаа хүүхдүүдийг үнэ төлбөргүй сургана гээд зарлачихсан байдаг. Гэхдээ ямар ч сургууль, энгийн нэг сургууль жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бэлэн авах тогтолцоо нь бүрдээгүй байгаад байдаг. Ийм 3 том асуудал над дээр илүү зонхилоод байгаа.

Тэгээд энэнтэй холбоотой жишээлбэл би нэг жишээн дээр энэ Ордны гадаа амьдарч байгаа, машиндаа амьдарч байгаа, хүүхэдтэйгээ амьдраад байгаа ийм 2 ээжийн асуудал жишээлбэл ирсэн. Тэгээд тэн дээр тэр ээжүүдийн хөндөөд байгаа асуудал нь болохлоор хүнсний эрүүл ахуйн асуудал байгаад байгаа. Гэтэл тэр ээж хүүхдээ далимд нь бас эрсдэлд оруулаад гудамжинд машинтайгаа ингэж амьдраад байгаа учраас хүүхдийг нь анхаарал аваач гэдэг саналыг Гэр бүлийн яаманд жишээлбэл уламжилсан байгаа.

Тэгэхээр энэ статистикийг харахлаар шийдвэрлэсэн гээд байгаа, тэгэхээр яг юуг нь шийдчихсэн юм бэ? Хүүхдийг нь ялгаж, хүүхдэд нь зориулсан нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлээд, хүүхдийг нь хамгаалалтад аваад шийдчихсэн юм уу, эсвэл шилжүүлснийгээ шийдчихсэн гээд байгаа юм уу гэдэг асуудал байна. Тэр нөгөө эмчилгээ байхгүй байгаа, надад ингээд мөнгө хэрэгтэй байна гэхийсэн хэцүү байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал дээр ЭМЯ жишээлбэл яаж шийдвэрлэсэн юм бэ гэдэг энэ мэдээллүүд нь эргэж ерөөсөө байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр тодруулж мэдээлэл авъя? Тэгээд гомдол, саналынхаа төрлийг яг ямар төрөл байна, эргээд яг юу хийсэн бэ? Тэгээд 3-д нь 11 11-нхаа цагийн хуваарийг нэг хэлчих үү? Баярлалаа.

О.Номинчимэг: Саранчулуун гишүүн энэ бид өнөөдөр 3 асуудал хэлэлцэж байгаа. Тэгээд сая таны асуусан энэ иргэдээс болон Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороодоос явуулсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн асуудлыг өмнөх асуудал дээр буюу 2 дахь асуудал дээр бид хэлэлцээд дуусаад, одоо 3 дахь асуудал буюу Хууль тогтоомжоор өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн асуудал руу орчихсон байгаад байгаа юм. Энэ нь болохоор яг таны ч гэсэн тэр Хог хаягдлын хууль, Хүнсний хууль, хяналт шалгалт, хэрэгжилтийн үнэлгээ хийх гэсэн энэ асуудлууд дээр бид төвлөрч байгаа. Тэгэхээр бид өмнөх асуудалтай холбоотой сая асуулт асуучих шиг боллоо л доо. Тийм. Ажлын хэсэг нь гараад, өөр ажлын хэсэг ороод ирчихсэн байгаа. Яах вэ одоо энэ ажлын хэсэг дээр байсан хүмүүс бол байгаа. Тэгэхээр гишүүнд яг энэ мэдээллийг нь та бүхэн өгчих үү? Одоо бид дараагийн асуудал руугаа орчихсон байгаа учраас юу яая тэгэх үү энүүгээр яачихъя. Бат-Эрдэнэ дарга, Эрдэнэбаяр дарга эд нар өмнөх асуудал дээр байсан. Гэхдээ хурлын дараа Саранчулуун гишүүнд энэ мэдээллийг нь өгөөдхөөрэй. Манай Байнгын хорооноос болон гишүүнээс явуулсан өргөдөлтэй холбоотой тодруулж асууж байгаа асуудал байна гэдгийг хэлье. Саранчулуун гишүүн өөр асуулт байгаа юу? Саранчулуун гишүүн нэмэлт тодруулга.

О.Саранчулуун: Яагаад энэ гомдол, санал гээд би түрүүн өөр Байнгын хорооны хуралтай байсан учраас хоцорч орлоо, уучлалт хүсье. Яагаад энийг асуусан гэхээр иргэд 11 11 рүү холбогдохоор энэ чинь ажлын бус цагаар байна гэдэг ийм гомдол байгаад байдаг байхгүй юу. Тэгэхээр хэрвээ ажлын бус цагаар бид чинь нөгөө цахим Монгол энэ тэр гээд зөндөө л шийдэл ярьж байгаа. Тэгэхээр 11 11-ээ арай илүү хүртээмжтэй болгоод, цагийг нь ингээд шийдэж сайжруулах ийм бололцоо байгаа юу, төлөвлөж байгаа юу гэдгийг мэдмээр байгаа юм. Тэгээд энэ яриагаар иргэд тэрийг олоод мэдчихвэл гомдлоо өгөх нэг шат ч гэсэн нээлттэй, хүртээмжтэй болох гээд байгаа юм. Бусад асуудлаар нь би цаасаар мэдээлэл авчихъя. Баярлалаа дарга.

О.Номинчимэг: Санал хэллээ. Мэдээллийг бас Саранчулуун гишүүнд гаргаж өгөөрэй. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Ганмаа гишүүнээр тасаллаа. Даваасамбуугийн Ганмаа гишүүн үг хэлье.

Д.Ганмаа: Энэ түрүүний асуудлаасаа арай тусдаа нэг энэ архи согтууруулах ундаатай холбоотой нэг юм асуух гэсэн юм. Энэ тэгэхдээ би нарийн харахгүй, хараагүй явсан байж магадгүй байна. Зүгээр энэ 2016 оны 64 дүгээр тушаалаар энэ Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалт гэж батлагдсан байсан боловч 22 оны А23 дугаар тушаалаар энэ хүчингүй болчихсон. Тэгээд шинээр энэ дээр зохицуулалт нь ямар зохицуулалт гарсан юм бэ? Сая 26 оны 2 сард нэг журам батлах нь батлагдсан байна. Тэгээд энэ ХХААХҮ-ийн сайд болон Эрүүл мэндийн сайдын 25 оны А616, А480 гэсэн ийм хамтарсан тушаалаар согтууруулах ундааны шошго, анхааруулгын загварт тавигдах шаардлага гэж батлагдсан боловч энэ зөвхөн шошгын асуудал болохоос импортын архины яг чанарын асуудлын техникийн тийм зохицуулалт нь нарийвчилж ороогүй байх юм, юм шиг харагдаж байна.

Тэр нөгөө хамгийн сүүлд гарсан журмыг би бүрэн, нарийн хараагүй байх магадлалтай. Энэ дээр зүгээр нэг намайг тайвшруулах үүднээс энэ техник, техникийн согтууруулах ундаа чинь Монголд нөгөө архи хордуулах, хордлогын том, том асуудлууд, яаралтай тусламж, түргэний аягүй гол асуудлууд. Тэгээд нас баралт, хүндрэлүүд, амиа хорлох гээд том, том эрүүл мэндийн том үр дагавартай асуудал байдаг учраас энэ импортоор оруулж ирж байгаа архины, согтууруулах ундааны техникийн шаардлагуудыг хэр зэрэг нарийн бид харах, үзэх, хянах ийм боломж нь байна гэдэг дээр уул нь ийм тодруулах байдлаар асуулт асууя гэж бодож байсан, амжаагүй учраас энийгээ үг болгоод, боломжтой бол та хэд бичгээр энэ дээр надад нэг хариулт явуулахгүй юу гэж хүсэхээр байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Архины чанартай, импортын архины чанартай холбоотой мэдээллийг, хяналттай холбоотой мэдээллийг холбогдох яам, тамгын газраас Ганмаа гишүүнд хүргүүлье. Өнөөдөр бидний хувьд Улсын Их Хурлын хууль тогтоомжоор өгсөн биелэлттэй холбоотой асуудлыг хэлэлцэж байгаа. Тэгээд энэ дээрээ бид хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү анхаарсан. Яагаад гэвэл өмнөх жилийн хүрээнд тал нь бол парламентын хувьд Өргөдлийн байнгын хороо байгаагүй учраас яг тухайлсан Өргөдлийн байнгын хорооны хянах асуудал дээр ингээд тодорхойлсон тийм тогтоол гараагүй. Гэхдээ дараа, дараагийн жил, яг энэ жилээс бид яг энэ хүүхдийн хоолны шим тэжээл, орон сууцын асуудал гээд чиг үүргээ хэрэгжүүлээд явж байгаагийн хүрээнд энэ яг чиг үүргээрээ бид дараа жилийн хууль тогтоомжоор өгсөн үүрэг чиглэлийн биелэлтээ бол хянаж, шалгаж, энэ дээрээ үр дүн хэр явж байна гэдгийг Өргөдлийн байнгын хорооны хувьд энэ зааг хязгаарыг гаргаад явахаар байгаа гэдгийг хэлье.

Өнөөдөр манай гишүүдийн асуултад дурдаж байгаа, яг гишүүдээс ирж байгаа өргөдөл, гомдлын биелэлт дээр ЗГХЭГ анхаараад, хариултыг нь өгөөрэй. Энэ асуудлууд дээр яг шилжүүлээд орхичихдог биш, иргэндээ очсон хариултууд хэр байна гэдэг дээр өгөхгүй бол иргэд нөгөө олон газар ер нь хандаад байгаагийн учир нь угаасаа өгөөд тэгээд л алга болчихдог учраас юу ч гэсэн бүгдэд нь өгье гэдэг ийм л аргатай болчихно. Хэн нэгэнд нь өгөөд, түүнийхээ дагуу шийдвэрлэгдээд, хариу ирдэг бол иргэд ч гэсэн тийм сэтгэлгээтэй болохгүй шүү дээ. Хаана нэгтээ шилжүүлээд, хэн нэгний ширээн дээр дарагдаад удчихдаг учраас л бүгдэд нь ер нь өргөдлөө гаргаж байгаа ийм жишгүүд бас байгаа гэдгийг хэлье. Өнөөдөр хууль,

тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж дууслаа.

16.53 цаг

Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА